	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	34	42	23.5	7.5

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 2 буюу 2.5, пүрэв гарагт 5 буюу 6.8, бямба гарагт 6 буюу 9.7, ням гарагт 8 буюу 13.1, мягмар гарагт 14 буюу 16.3, даваа гарагт 18 буюу 23.4 хувиар тус тус өсч, баасан гарагт үйлдэгдсэн хэрэг 4 буюу 5.1 хувиар буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 8 буюу 8.4, 19-22 цагийн хооронд 9 буюу 11.0, 22-06 цагийн хооронд 48 буюу 23.0 хувиар тус тус өсч, 14-19 цагийн хооронд 16 буюу 12.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад авто замд үйлдэгдсэн хэрэг 8 буюу 22.9, аж ахуйн нэгж, байгууллагад 3 буюу 23.1, бусад газарт 47 буюу 23.9, олон нийтийн газарт 9 буюу 45.0 хувиар, төрийн бус байгууллагад 2 буюу 2.0 дахин тус тус өсч, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 3 буюу 1.7, гудамж талбайд 12 буюу 21.8, төрийн байгууллагад 5 буюу 29.4 хувиар тус тус буурчээ.



Гэр, орон сууц 31.2% | Гудамж, талбай 7.6% | Олон нийтийн газар 5.1% | Аж ахуйн нэгж 2.8% | Авто зам 7.6% | Бусад газар 45.7%

1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 144 буюу 25.4 хувь нь согтуугаар, 7 буюу 1.2 хувь нь хүүхэд оролцож, 45 буюу 7.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 39 буюу 6.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 40 буюу 7.0 хувь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Архангай аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 274 буюу 48.2 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 54.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.5 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 4.1 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 557 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 52 хэрэг буюу 10.3 хувиар, үүнээс 304 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 36 буюу 13.4 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 368 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41 буюу 12.5 хувиар өссөн. Холбогдогчдын 339 буюу 92.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 10.8 хувиар, 29 буюу 7.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 38.1 хувиар тус тус өсч, 8 буюу 2.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.3 хувиар буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн

Гэмт хэргийн улмаас 570 хүн хохирч, үүнээс 27 хүн нас барж, 182 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 43 буюу 8.2, нас барсан хүн 9 буюу 50.0 хувиар тус тус өсч, гэмтсэн хүн 33 буюу 15.3 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол

Хүнд учирсан 2169.0 сая төгрөгийн хохирлын 53.9 хувийг нөхөн төлүүлж, 93.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 824.0 буюу 61.3, нөхөн төлүүлсэн хохирол 628.4 буюу 2.2 дахин тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 17.2 буюу 15.6 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил

Архангай аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 32.539 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 10.207 буюу 45.7 хувиар, 32.500 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 10.211 буюу 45.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 31.055 буюу 95.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1011 буюу 3.1 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 139 буюу 0.4 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 334 буюу 1.1 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 31.614 хүн, 3 хуулийн этгээдийг 1060.4 сая төгрөгөөр торгох, 404 хүнийг баривчлах, 479 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 9856 буюу 45.3 хувиар, баривчилсан шийтгэл 179 буюу 79.6 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 173 буюу 56.5 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Архангай аймагт нийт 640 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 36 буюу 6.0 хувиар өссөн байна.

---oooOooo---

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 3085 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 550 буюу 17.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2535 буюу 82.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 473 буюу 18.1, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 69 буюу 14.3, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 404 буюу 19.0 хувиар тус тус өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 306 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 12 буюу 3.8 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.7 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 333, сард 28, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Алтай сум	6	13	7	2.2 дах
2	Алтанцөгц сум	3	7	4	2.3 дах
3	Баяннуур сум	18	13	-5	-27.8
4	Булган сум	5	6	1	20.0
5	Буянт сум	12	8	-4	-33.3
6	Цэнгэл сум	18	26	8	44.4
7	Бугат сум	17	14	-3	-17.6
8	Дэлүүн сум	7	5	-2	-28.6
9	Ногооннуур сум	26	21	-5	-19.2
10	Өлгий сум	175	167	-8	-4.6
11	Сагсай сум	11	7	-4	-36.4
12	Толбо сум	10	7	-3	-30.0
13	Улаан хус сум	10	12	2	20.0

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 244 буюу 79.7 хувь нь хөнгөн, 62 буюу 20.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 2.1 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 21.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он

1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	4	4	0	1.3
	Үүнээс: Хүнийг алах	2	3	50.0	1.0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	109	88	-19.3	28.8
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	4	100	1.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	8	9	12.5	2.9
	Үүнээс: Хүчиндэх	8	9	12.5	2.9
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	3	1	-66.7	0.3
5	Хүүхдийн эсрэг	0	1		0.3
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	131	139	6.1	45.4
	Үүнээс: Хулгайлах	67	55	-17.9	18.0
	Залилах	18	38	2.1 дах	12.4
	Дээрэмдэх	2	4	2.0 дах	1.3
	Мал хулгайлах	23	13	-43.5	4.2
7	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	1			
8	Үндэсний аюулгүй байдлыг эсрэг	4			
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1			
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	10	2	-80.0	0.7
11	Авлигын эсрэг гэмт хэрэг	13	7	-46.2	2.3
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	10	14	40.0	4.6
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг	6	19	3.1 дах	6.2
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	18	22	22.2	7.2
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	18	22	22.2	7.2

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бямба гарагт үйлдэгдсэн хэрэг 4 буюу 10.0, ням гарагт 6 буюу 19.4, пүрэв гарагт 18 буюу 54.5 хувиар тус тус өсч, лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 8 буюу 14.8, даваа гарагт 9 буюу 18.4, мягмар гарагт 12 буюу 20.7, баасан гарагт 11 буюу 20.8 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06 -14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 16 буюу 17.0, 14-19 цагийн хооронд 5 буюу 5.5 хувиар тус тус буурч, 19-22 цагийн хооронд 5 буюу 9.4, 22-06 цагийн хооронд 4 буюу 5.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.





1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж ахуйн нэгжид үйлдэгдсэн хэрэг 5 буюу 38.5, олон нийтийн газар 7 буюу 38.9, авто замд үйлдэгдсэн хэрэг 9 буюу 69.2 хувиар тус тус өсч, гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг 2 буюу 6.1, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 8 буюу 9.6, төрийн бус байгууллагад 1 буюу 20.0, төрийн байгууллагад 15 буюу 42.9, бусад газар 7 буюу 5.9 хувиар тус тус бүурсан.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 61 буюу 19.9 хувь нь согтуугаар, 15 буюу 4.9 хувь нь хүүхэд оролцож, 33 буюу 10.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 19 буюу 6.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас болон бүлэглэн гүйцэтгэж, 1 буюу 0.3 хувь нь галт зэвсгээр үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Баян-Өлгий аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 119 буюу 38.9 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 74.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 11.4 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 15.5 нэгжээр өндөр байна.



2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 271 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3 хэрэг буюу 1.1 хувиар буурч, түүнээс 201 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 29 буюу 16.9 хувиар өссөн байна

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 287 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 буюу 2.1 хувиар өссөн. Холбогдогчдын 28 буюу 9.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 20.0 хувиар,16 буюу 5.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.3 хувиар тус тус буурч, 259 буюу 90.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 5.3 хувиар өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 312 хүн, 3 хуулийн этгээд хохирч, үүнээс 11 хүн нас барж, 104 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 12 буюу 4.0 хувиар өсч, гэмтсэн хүн 9 буюу 8.0 хувиар буурч, нас барсан хүн өмнөх оны түвшинд байна.



4.2 Учирсан хохирол



Хүн, хуулийн этгээдэд учирсан 1131.4 сая төгрөгийн хохирлын 53.4 хувийг нөхөн төлүүлж, 172.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 598.8 буюу 2.1 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 275.7 буюу 83.9, битүүмжилсэн хөрөнгө 36.9 буюу 27.2 хувиар тус тус өссөн байна.

Тав. Зөрчил

Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 14.146 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3.386 буюу 31.5 хувиар, 14.070 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3404 буюу 31.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 12.469 буюу 88.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 942 буюу 6.7 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 113 буюу 0.8 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 622 буюу 4.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 13.382 хүн, 1 хуулийн этгээдийг 577.5 сая төгрөгөөр торгох, 265 хүнийг баривчлах, 422 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгох шийтгэл 3233 буюу 31.9 хувиар, баривчилсан шийтгэл 44 буюу 19.9 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 126 буюу 42.6 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Баян-Өлгий аймагт нийт 1190 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15 буюу 1.2 хувиар буурсан байна.

---oooOooo---

БАЯНХОНГОР АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Баянхонгор аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 4296 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1014 буюу 23.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3282 буюу 76.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 500 буюу 13.2, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 62 буюу 6.5, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 438 буюу 15.4 хувиар тус тус өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Нийт 642 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 61 буюу 10.5 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 5.7 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 448, сард 37, хоногт 1 хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баацагаан сум	11	10	-1	-9.1
2	Баян овоо сум	24	48	24	2.0 дах
3	Баянбулаг сум	2		-2	
4	Баянговь сум	8	11	3	37.5
5	Баянлиг сум	5	16	11	3.2
6	Баянөндөр сум	5	5	0	0.0
7	Баянхонгор сум	371	379	8	2.2
8	Баянцагаан сум	5	6	1	1.2
9	Богд сум	15	10	-5	-33.3
10	Бөмбөгөр сум	35	37	2	5.7
11	Бууцагаан сум	5	17	12	3.4 дах
12	Галуут сум	22	18	-4	-18.2
13	Гурванбулаг сум	5	13	8	2.6
14	Жаргалант сум	10	8	-2	-20.0
15	Жинст сум	9	14	5	55.6
16	Шинэжинст сум	5	4	-1	-20.0
17	Эрдэнэцогт сум	12	14	2	16.7
18	Заг сум	11	6	-5	-45.5
19	Өлзийт сум	17	19	2	11.8
20	Хүрээмарал сум	4	7	3	75.0

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 477 буюу 74.3 хувь нь хөнгөн, 165 буюу 25.7 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 6.5 хувиар, хүнд гэмт хэрэг 24.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	7	15	2.2 дах	2.3
	Үүнээс: Хүнийг алах	2	7	3.5 дах	3.5 дах
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	203	188	-7.4	29.3
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3	1	-66.7	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	21	41	95.2	6.4
	Үүнээс: Хүчиндэх	17	22	29.4	3.4
4	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		2		0.3
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	315	326	3.5	50.8
	Үүнээс: Хулгайлах	206	165	-19.9	25.7
	Залилах	35	26	-25.7	4.1
	Дээрэмдэх	6	1	-83.3	0.2
	Мал хулгайлах	51	101	98.0	15.7
6	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.3
7	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3	1	-66.7	0.2
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	5	5.0 дах	0.8
9	Авлигын эсрэг гэмт хэрэг	5	14	2.8 дах	2.2
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3	3	0.0	0.5
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг	11	20	81.8	3.1
12	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг		1		0.2
13	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	11	24	2.2 дах	3.6
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	11	24	2.2 дах	3.6

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ням гарагт үйлдэгдсэн хэрэг 1 буюу 1.2, бямба гарагт 5 буюу 6.7, мягмар гарагт 11 буюу 13.3, даваа 16 буюу 20.3, пүрэв гарагт 31 буюу 39.2 хувиар тус тус өсч, лхагва гарагт 1 буюу 1.1, баасан гарагт үйлдэгдсэн хэрэг 2 буюу 2.2 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 25 буюу 22.5, 14-19 цагийн хооронд 2 буюу 1.4, 19-22 цагийн хооронд 10 буюу 9.7, 22-06 цагийн хооронд 24 буюу 10.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 22 буюу 10.9, төрийн байгууллагад 4 буюу 14.8, бусад газарт 61 буюу 38.6 хувиар, авто замд 16 буюу 3.3 дахин тус тус өсч, гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг 4 буюу 4.6, аж ахуйн нэгж, байгууллагад 9 буюу 60.0, олон нийтийн газарт 28 буюу 37.8, төрийн бус байгууллагад 5 буюу 45.5 хувиар тус тус буурсан байна. Нийтийн тээвэрт 4 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 130 буюу 20.2 хувь нь согтуугаар, 16 буюу 2.5 хувь нь хүүхэд оролцож, 51 буюу 7.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 17 буюу 2.6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 64 буюу 10.0 хувь нь бүлэглэн гүйцэтгэж, 1 буюу 0.2 хувь нь галт зэвсгээр үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Баянхонгор аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 305 буюу 47.5 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 53.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.0 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 5.3 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 595 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 65 хэрэг буюу 12.3 хувиар, үүнээс 318 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 40 буюу 14.4 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 441 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45 буюу 11.4 хувиар өссөн. Холбогдогчдын 398 буюу 90.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 10.2 хувиар, 43 буюу 9.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 22.9 хувиар тус тус өсч, 21 буюу 4.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.4 хувиар буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн

Гэмт хэргийн улмаас 637 хүн хохирч, үүнээс 28 хүн нас барж, 198 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 57 буюу 9.8 хувь, нас барсан хүн 16 буюу 2.3 дахин өсч, гэмтсэн хүн 12 буюу 5.7 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол



Хүнд учирсан 1665.7 сая төгрөгийн хохирлын 34.2 хувийг нөхөн төлүүлж, 237.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 328.7 буюу 24.6 хувь, битүүмжилсэн хөрөнгө 157.8 буюу 3.0 дахин тус тус өсч, нөхөн төлүүлсэн хохирол 25.6 буюу 4.3 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил

Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 29.352 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 8164 буюу 38.5 хувиар, 29.279 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 8227 буюу 39.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 28042 буюу 95.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 240 буюу 0.8 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 134 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 936 буюу 3.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 28.196 хүнийг 968.8 сая төгрөгөөр торгох, 395 хүнийг баривчлах, 688 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 8160 буюу 40.7 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 138 буюу 25.1 хувиар тус тус өсч, баривчилсан шийтгэл 71 буюу 15.2 хувиар буурсан байна.

2019 онд Баянхонгор аймагт нийт 1240 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 34 буюу 2.7 хувиар буурсан байна.

БУЛГАН АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Булган аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 2255 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 645 буюу 28.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1610 буюу 71.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 445 буюу 24.6, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 106 буюу 19.7, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 339 буюу 26.7 хувиар тус тус буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 459 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 115 буюу 33.4 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.1 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 326, сард 27, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/

1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баян Агт сум	8	13	5	62.5
2	Баяннуур сум	12	12	0	0.0
3	Бугат сум	25	39	14	56.0
4	Булган сум	98	93	-5	-5.1
5	Бүрэг хангай сум	27	28	1	3.7
6	Гурванбулаг сум	17	21	4	23.5
7	Дашинчилэн сум	7	13	6	85.7
8	Могод сум	9	13	4	44.4
9	Орхон сум	35	75	40	2.2 дах
10	Рашаант сум	10	16	6	60.0
11	Сайхан сум	10	21	11	2.1 дах
12	Сэлэнгэ сум	15	23	8	53.3
13	Тэшиг сум	14	8	-6	-42.9
14	Хангал сум	20	22	2	10.0
15	Хишигөндөр сум	12	29	17	2.4 дах
16	Хутаг өндөр сум	25	33	8	32.0

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 369 буюу 80.4 хувь нь хөнгөн, 90 буюу 19.6 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 38.7 хувиар, хүнд гэмт хэрэг 15.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	14	14	0.0	3.1
	Үүнээс: Хүнийг алах	3	4	33.3	0.9
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	94	98	4.3	21.4
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	3	50.0	0.7
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5	15	3.0 дах	3.3
	Үүнээс: Хүчиндэх	5	15	3.0 дах	3.3
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	2			
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1			
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	144	240	66.7	52.3
	Үүнээс: Хулгайлах	84	82	-2.4	17.9
	Залилах	5	18	3.6 дах	3.9
	Дээрэмдэх	4	3	-25.0	0.7
	Мал хулгайлах	37	117	3.2 дах	25.5
7	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		1		0.2
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	3	9	3.0 дах	2.0
9	Авлигын эсрэг гэмт хэрэг	5	8	60.0	1.7
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	5	4	-20.0	0.8
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг	40	46	15.0	10.0
12	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1			
13	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	30	24	-20.0	5.2
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	29	24	-17.2	5.2

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бямба гарагт үйлдэгдсэн хэрэг 3 буюу 5.7, даваа гарагт 15 буюу 30.6, ням гарагт 17 буюу 35.4, пүрэв гарагт 28 буюу 52.8, лхагва гарагт 26 буюу 56.5 хувиар, мягмар гарагт 33 буюу 2.0 дахин тус тус өсч, баасан гарагт үйлдэгдсэн хэрэг 7 буюу 11.3 хувиар буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 25 буюу 37.3, 14-19 цагийн хооронд 16 буюу 19.0, 19-22 цагийн хооронд 30 буюу 50.8, 22-06 цагийн хооронд 44 буюу 32.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.





1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 4 буюу 3.4, төрийн байгууллагад 3 буюу 18.8, аж ахуйн нэгж, байгууллагад 4 буюу 36.4, гудамж талбайд 10 буюу 40.0, бусад газарт 87 буюу 66.4, олон нийтийн газарт 10 буюу 83.3 хувиар тус тус өсч, авто замд үйлдэгдсэн хэрэг 3 буюу 11.1 хувиар буурч, төрийн бус байгууллагад үйлдэгдсэн хэрэг өмнөх оны түвшинд байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 76 буюу 16.6 хувь нь согтуугаар, 17 буюу 3.7 хувь нь хүүхэд оролцож, 31 буюу 6.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 21 буюу 4.6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 41 буюу 8.9 хувь нь бүлэглэн, 1 буюу 0.2 хувь нь галт зэвсгээр үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Булган аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 234 буюу 51.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 59.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.2 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 0.6 нэгжээр их байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 430 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 131 хэрэг буюу 43.8 хувиар, үүнээс 255 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 77 буюу 43.3 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 306 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45 буюу 17.2 хувиар өссөн. Холбогдогчдын 279 буюу 91.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 17.7 хувиар, 27 буюу 8.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 12.5 хувиар, 19 буюу 6.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 дахин тус тус өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 450 хүн, 1 хуулийн этгээд хохирч, үүнээс 26 хүн нас барж, 113 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 100 буюу 28.6, нас барсан хүн 9 буюу 52.9 хувиар тус тус өсч, гэмтсэн хүн 18 буюу 13.7 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол



Хүн, хуулийн этгээдэд учирсан 1471.9 сая төгрөгийн хохирлын 41.6 хувийг нөхөн төлүүлж, 124.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 383.5 буюу 35.2 хувиар өсч, нөхөн төлүүлсэн хохирол 7.3 буюу 1.2, битүүмжилсэн хөрөнгө 94.3 буюу 43.1 хувиар тус тус буурсан байна.

Тав. Зөрчил

Булган аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 31.461 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9883 буюу 45.8 хувиар, 31.386 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9974 буюу 46.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 30.563 буюу 97.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 227 буюу 0.7 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 187 буюу 0.6 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 484 буюу 1.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 30818 хүн, 2 хуулийн этгээдийг 994.8 сая төгрөгөөр торгох, 277 хүнийг баривчлах, 289 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 9830 буюу 46.8 хувиар, баривчилсан шийтгэл 98 буюу 54.7 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 45 буюу 18.4 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Булган аймагт нийт 719 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 186 буюу 34.9 хувиар өссөн байна.

---oooOooo---

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 1407 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 515 буюу 36.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 892 буюу 63.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 293 буюу 26.3, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 123 буюу 31.4, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 170 буюу 23.5 хувиар тус тус өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 235 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 32 буюу 15.8 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.1 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 191, сард 16, 2 хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт Тоо	Хувь
1	Алтай сум	5	5	0	0.0
2	Баянуул сум	2	8	6	4.0 дах
3	Бигэр сум	3	2	-1	-34.0
4	Бугат сум	3	4	1	33.3
5	Дарви сум	5	4	-1	-20.0
6	Дэлгэр сум	12	16	4	33.3
7	Есөнбулаг сум	120	123	3	2.5
8	Жаргалан сум	2	9	7	4.5 дах
9	Тайшир сум	9	11	2	22.2
10	Тонхил сум	7	4	-3	-42.9
11	Төгрөг сум	2	2	0	0.0
12	Халиун сум	10	8	-2	-20.0
13	Хөхморьт сум	4	4	0	0.0
14	Цогт сум	8	14	6	75.0
15	Цээл сум	3	6	3	2.0 дах
16	Чандмань сум	3	5	2	66.7
17	Шарга сум	2	8	6	4.0 дах
18	Эрдэнэ сум	3	2	-1	-33.3

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 178 буюу 75.8 хувь нь хөнгөн, 57 буюу 24.2 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 14.8 хувиар, хүнд гэмт хэрэг 18.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	4	10	2.5 дах	4.3
	Үүнээс: Хүнийг алах	2	2	0.0	0.9
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	50	66	32.0	28.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5	2	-60.0	0.9
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	3	50.0	1.3
	Үүнээс: Хүчиндэх	2	3	50.0	1.3
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1			
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	125	119	-4.8	50.6
	Үүнээс: Хулгайлах	49	54	10.2	23.0
	Залилах	45	22	-51.1	9.4
	Дээрэмдэх	1	3	3.0 дах	1.3
	Мал хулгайлах	13	24	84.6	10.2
6	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	1			
7	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг		2		0.9
8	Авлигын эсрэг гэмт хэрэг	2	17	8.5 дах	7.2
9	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.4
10	Хүрээлэн байгаа орчны эсрэг	3	4	33.3	1.7
11	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	14	13	-7.1	5.5
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	14	13	-7.1	5.5

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бямба гарагт үйлдэгдсэн хэрэг 1 буюу 3.4, ням гарагт 4 буюу 19.0, баасан гарагт 6 буюу 23.1, лхагва гарагт 9 буюу 28.1, пүрэв гарагт 9 буюу 39.1, мягмар гарагт 14 буюу 51.9 хувиар тус тус өсч, даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 11 буюу 24.4 хувиар буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 27 буюу 48.2, 14-19 цагийн хооронд 4 буюу 6.6, 22-06 цагийн хооронд 5 буюу 8.3 хувиар тус тус өсч, 19-22 цагийн хооронд 4 буюу 15.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад авто замд үйлдэгдсэн хэрэг 1 буюу 8.3, аж ахуйн нэгж, байгууллагад 2 буюу 15.4, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 31 буюу 91.2 хувиар, төрийн байгууллагад 17 буюу 2.9 дахин тус тус өсч, бусад газарт үйлдэгдсэн хэрэг 5 буюу 6.0,

гудамж талбайд 3 буюу 11.6, олон нийтийн газарт 11 буюу 45.8 хувиар тус тус буурсан бол төрийн бус байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны түвшинд байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 55 буюу 23.4 хувь нь согтуугаар, 20 буюу 8.5 хувь нь хүүхэд оролцож, 25 буюу 10.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 5 буюу 2.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 21 буюу 8.9 хувь нь бүлэглэн үйлдэж, 2 буюу 0.9 хувь нь галт зэвсгээр үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Говь-Алтай аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 123 буюу 52.3 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 61.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.8 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 2.6 нэгжээр их байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 212 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 24 хэрэг буюу 12.8 хувиар, үүнээс 130 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 20 буюу 18.2 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 166 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22 буюу 15.2 хувиар өссөн. Холбогдогчдын 146 буюу 88.0 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 10.6 хувиар, 20 буюу 12.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 66.7 хувиар, 29 буюу 17.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4 дахин тус тус өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн

Гэмт хэргийн улмаас 228 хүн хохирч, үүнээс 7 хүн нас барж, 81 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 19 буюу 9.1, гэмтсэн хүн 19 буюу 30.6 хувиар тус тус өсч, нас барсан хүн 2 буюу 22.2 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол



Хүнд учирсан 1196.4 сая төгрөгийн хохирлын 79.9 хувийг нөхөн төлүүлж, 68.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 699.4 сая буюу 2.4, нөхөн төлүүлсэн хохирол 770.4 сая буюу 5.1, битүүмжилсэн хөрөнгө 66 сая буюу 27.6 дахин тус тус өссөн байна.

Тав. Зөрчил

Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 15624 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6168 буюу 65.2 хувиар, 15572 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6175 буюу 65.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 14128 буюу 90.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1080 буюу 6.9 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 39 буюу 0.2 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 377 буюу 2.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 14999 хүн, 10 хуулийн этгээдийг 578.8 сая төгрөгөөр торгох, 185 хүнийг баривчлах, 378 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 5916 буюу 65.1 хувиар, баривчилсан шийтгэл 71 буюу 62.3 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 178 буюу 89.0 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Говь-Алтай аймагт нийт 507 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 175 буюу 52.7 хувиар өссөн байна.

---oooOooo---

ГОВЬСҮМБЭР АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс 2019 онд хүн, хуулийн этгээдээс 801 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 270 буюу 33.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 531 буюу 66.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 37 буюу 4.8, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 86 буюу 19.3 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 49 буюу 15.3 хувиар буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 154 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 22 буюу 12.5 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 1.4 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 171, сард 14 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/

Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баянтал сум	19	16	-3	-15.8
2	Сүмбэр сум	135	118	-17	-12.6
3	Шивээговь	22	20	-2	-9.1

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 134 буюу 87.0 хувь нь хөнгөн, 20 буюу 13.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 8.8 хувиар, хүнд гэмт хэрэг 31.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он

1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	3	4	33.3	2.6
	Үүнээс: Хүнийг алах	2	1	-50.0	0.6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	91	62	-31.9	40.3
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	4	2.0 дах	2.6
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	10	5	-50.0	3.2
	Үүнээс: Хүчиндэх	3	5	66.7	3.2
4	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	52	61	17.3	39.7
	Үүнээс: Хулгайлах	34	27	-20.6	17.5
	Залилах	3	15	5.0 дах	9.7
	Дээрэмдэх		1		0.6
	Мал хулгайлах	7	12	71.4	7.8
5	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.6
6	Авлигын эсрэг гэмт хэрэг	6	6	0.0	3.9
7	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		3		1.9
8	Хүрээлэн байгаа орчны эсрэг	1			
9	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	11	12	9.1	7.8
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	11	12	9.1	7.8

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ням гарагт үйлдэгдсэн хэрэг 2 буюу 8.3 хувиар, лхагва гарагт 12 буюу 60.0 хувиар тус тус өсч, пүрэв гарагт үйлдэгдсэн хэрэг 3 буюу 11.5, даваа гарагт 5 буюу 17.9, мягмар гарагт 7 буюу 26.9, баасан гарагт 10 буюу 35.7, бямба гарагт 11 буюу 45.8 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг өмнөх оны мөн үеийн түвшинд, 14-19 цагийн хооронд 13 буюу 28.9 хувиар, 22-06 цагийн хооронд 10 буюу 16.4 хувиар тус тус буурч, 19-22 цагийн хооронд 1 буюу 3.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад газарт үйлдэгдсэн хэрэг 2 буюу 5.9, авто замд 2 буюу 18.2, олон нийтийн газарт 3 буюу 37.5 хувиар тус тус өсч, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 7 буюу 11.5, төрийн байгууллагад үйлдэгдсэн хэрэг 4 буюу 36.4, гудамж

талбайд 17 буюу 44.7 хувиар тус тус буурч, аж ахуйн нэгж, байгууллагад өмнөх оны мөн үеийн түвшинд, нийтийн тээвэрт 1 хэрэг бүртгэгдсэн байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 63 буюу 40.9 хувь нь согтуугаар, 2 буюу 1.3 хувь нь хүүхэд оролцож, 17 буюу 11.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 21 буюу 13.6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 9 буюу 5.8 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Говьсүмбэр аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 65 буюу 42.2 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 58.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 4.3 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 0.4 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 139 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 32 хэрэг буюу 18.7 хувиар, үүнээс 81 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 26 буюу 24.3 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 103 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21 буюу 16.9 хувиар буурсан. Холбогдогчдын 89 буюу 86.4 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 16.0 хувиар,14 буюу 13.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 22.2 хувиар, 4 буюу 3.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.3 хувиар тус тус буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн

Гэмт хэргийн улмаас 156 хүн хохирч, үүнээс 6 хүн нас барж, 81 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 18 буюу 10.3, гэмтсэн хүн 26 буюу 24.3 хувиар тус тус буурч, нас барсан хүн 1 буюу 20.0 хувиар өссөн байна.



4.2. Учирсан хохирол



Хүнд учирсан 405.1 сая төгрөгийн хохирлын 30.0 хувийг нөхөн төлүүлж, 49.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 143.8 буюу 26.2 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 169.3 буюу 58.2 хувиар тус тус буурсан, битүүмжилсэн хөрөнгө 28.9 буюу 2.4 дахин өссөн байна.

Тав. Зөрчил

Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтсийн хэмжээнд нийт 24.769 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5990 буюу 31.9 хувиар, 24.746 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6014 буюу 32.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 24.243 буюу 97.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 352 буюу 1.4 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 28 буюу 0.1 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 146 буюу 0.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 24.434 хүн, 1 хуулийн этгээдийг 770.5 сая төгрөгөөр торгох, 131 хүнийг баривчлах, 180 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 5977 буюу 32.4 хувиар, баривчилсан шийтгэл 23 буюу 21.3 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 22 буюу 13.9 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Говьсүмбэр аймагт нийт 889 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 169 буюу 23.5 хувиар өссөн байна.

---oooOooo---

ДАРХАН-УУЛ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 5541 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1368 буюу 24.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 4173 буюу 75.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 356 буюу 6.9, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 113 буюу 9.0, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 243 буюу 6.2 хувиар тус тус өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 803 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 15 буюу 1.8 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 7.2 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 729, сард 61, хоногт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/

Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Дархан сум	680	689	-9	1.3
2	Орхон сум	23	23	0	0.0
3	Хонгор сум	64	55	-9	-14.1
4	Шарын гол сум	51	36	-15	-29.4

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 666 буюу 82.9 хувь нь хөнгөн, 137 буюу 17.1 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 1.5 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 15.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	17	17	0.0	2.1
	Үүнээс: Хүнийг алах	3	7	2.3 дах	0.9
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	262	265	1.1	33.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	6	5	-16.7	0.6
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	16	8	-50.0	1.0
	Үүнээс: Хүчиндэх	14	8	-42.9	1.0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	4	5	25.0	0.6
5	Эрүүл мэндийн эсрэг	1	2	2 дах	0.3
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	408	444	8.8	55.3
	Үүнээс: Хулгайлах	213	187	-12.2	23.3
	Залилах	86	124	44.2	15.4
	Дээрэмдэх	40	28	-30.0	3.5
	Мал хулгайлах	14	35	2.5 дах	4.4
7	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг		3		0.4
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	11	3	-72.7	0.4
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	5	5 дах	0.6
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	9	6	-33.3	0.8
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	6	5	-16.6	0.6
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг	27	9	-66.6	1.1
13	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	54	30	-44.4	3.7
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	53	30	-43.4	3.7
14	Цэргийн албаны эсрэг	2	1	-50.0	0.1

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бямба гарагт 12 буюу 13.0, мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 9 буюу 7.9, баасан гарагт 7 буюу 6.0 хувиар тус тус өсч, ням гарагт 23 буюу 20.0, лхагва гарагт 12 буюу 9.2, даваа гарагт 6 буюу 4.6, пүрэв гарагт 2 буюу 1.7 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 7 буюу 4.0, 22-06 цагийн хооронд 36 буюу 14.6 хувиар тус тус өсч, 14-19 цагийн хооронд 37 буюу 13.4, 19-22 цагийн хооронд 21 буюу 17.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийтийн тээвэрт үйлдэгдсэн хэрэг 2 буюу 50.0, олон нийтийн газарт 33 буюу 30.6, аж ахуйн нэгж, байгууллагад 5 буюу 6.8, гэр орон сууцанд 6 буюу 2.3 хувиар тус тус өсч, авто замд үйлдэгдсэн хэрэг 24 буюу 43.6, төрийн бус байгууллагад 3 буюу 50.0, төрийн байгууллагад 8 буюу 34.8, гудамж талбайд 22 буюу 12.4, бусад газарт 4 буюу 3.5 хувиар тус тус буурсан байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 206 буюу 25.7 хувь нь согтуугаар, 27 буюу 3.4 хувь нь хүүхэд оролцож, 126 буюу 15.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 67 буюу 8.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 61 буюу 7.6 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Дархан-Уул аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 388 буюу 48.3 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 58.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.2 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 0.5 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 662 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 54 хэрэг буюу 7.5 хувиар, үүнээс 385 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 54 буюу 12.3 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 616 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 буюу 2.7 хувиар өссөн. Холбогдогчдын 509 буюу 82.6 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.4, 107 буюу 17.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 9.2 хувиар тус тус өсч, 52 буюу 8.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.5 хувиар буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн

Гэмт хэргийн улмаас 835 хүн хохирч, үүнээс 25 хүн нас барж, 298 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 13 буюу 1.6 хувиар өсч, нас барсан хүн 1 буюу 3.8, гэмтсэн хүн 48 буюу 13.9 хувиар тус тус буурсан байна.



4.2. Учирсан хохирол



Хүнд учирсан 2586.9 сая төгрөгийн хохирлын 42.8 хувийг нөхөн төлүүлж, 93.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 605.9 сая буюу 30.6, нөхөн төлүүлсэн хохирол 318.8 сая буюу 40.4, битүүмжилсэн хөрөнгө 25.0 сая буюу 36.6 хувиар тус тус өссөн байна.

Тав. Зөрчил

Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 63852 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 14636 буюу 29.7 хувиар, 63773 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 14752 буюу 30.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 61275 буюу 96.0 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 431 буюу 0.7 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 128 буюу 0.2 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2018 буюу 3.1 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 62280 хүн, 10 хуулийн этгээдийг 1920.3 сая төгрөгөөр торгох, 317 хүнийг баривчлах, 1166 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 14574 буюу 30.5 хувиар, баривчилсан шийтгэл 66 буюу 26.3 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 111 буюу 10.5 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Дархан-Уул аймагт нийт 4019 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 489 буюу 10.8 хувиар буурсан байна.

---oooOooo---

ДОРНОГОВЬ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Дорноговь аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 2538 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 935 буюу 36.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1603 буюу 63.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 70 буюу 2.7 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 221 буюу 12.1 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 151 буюу 19.3 хувиар өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 550 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 33 буюу 6.4 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.9 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 570, сард 47, хоногт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Айраг сум	22	14	-8	-36.4
2	Алтанширээ сум	12	13	1	8.3
3	Даланжаргалан сум	27	36	9	33.3
4	Дэлгэрэх сум	5	17	12	3.4 дах
5	Замын үүд сум	200	197	-3	-1.5
6	Иххэт сум	10	26	16	2.6 дах
7	Мандах сум	6	3	-3	-50.0
8	Өргөн сум	8	8	0	0.0
9	Сайншанд сум	167	185	18	10.8
10	Сайхандулаан сум	9	8	-1	-11.1
11	Улаанбадрах сум	11	6	-5	-45.5
12	Хатанбулаг сум	22	16	-6	-27.3
13	Хөвсгөл сум	10	8	-2	-20.0
14	Эрдэнэ сум	8	13	5	62.5

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 422 буюу 76.7 хувь нь хөнгөн, 128 буюу 23.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 2.2 хувиар, хүнд гэмт хэрэг 23.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	8	10	25.0	1.8
	Үүнээс: Хүнийг алах	2	3	50.0	0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	143	169	18.2	30.7
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		2		0.4
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	19	27	42.1	4.9
	Үүнээс: Хүчиндэх	18	17	-5.6	3.1
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		5		0.9
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	219	215	-1.8	39.1
	Үүнээс: Хулгайлах	111	107	-3.6	19.5
	Залилах	37	31	-16.2	5.6
	Дээрэмдэх	7	6	-14.3	1.1
	Мал хулгайлах	30	26	-13.3	4.7
6	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	26	35	34.6	6.4
7	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	22	1	-95.5	0.2
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	10	6	-40.0	1.1
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	4	1	-75.0	0.2
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	4	7	75.0	1.3
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	14	5	-64.3	0.9
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг	5	18	3.6 дах	3.3
13	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
14	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		3		0.5
15	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	42	44	4.8	8.0
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	40	44	10.0	8.0
16	Цэргийн албаны эсрэг	1	3	3.0 дах	0.5

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 1 буюу 1.2, мягмар гарагт 3 буюу 3.9, ням гарагт 9 буюу 14.1, пүрэв гарагт 11 буюу 16.2, бямба гарагт 23 буюу 41.1 хувиар тус тус өсч, лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 7 буюу 8.0, баасан гарагт 7 буюу 8.6 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 6 буюу 4.1, 14-19 цагийн хооронд 16 буюу 13.9, 19-22 цагийн хооронд 25 буюу 38.5 хувиар тус тус өсч, 22-06 цагийн хооронд 14 буюу 7.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж ахуйн нэгж, байгууллагад үйлдэгдсэн хэрэг 4 буюу 15.4, авто замд 7 буюу 18.9, гэр орон сууцанд 42 буюу 30.2, олон нийтийн газарт 11 буюу 37.9, бусад газарт 7 буюу 4.9 хувиар тус тус өсч, төрийн бус байгууллагад үйлдэгдсэн хэрэг 1 буюу 11.1, төрийн байгууллагад үйлдэгдсэн хэрэг 9 буюу 23.7, гудамж талбайд 25 буюу 28.7, нийтийн тээвэрт 3 буюу 30.0 хувиар тус тус буурчээ.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 179 буюу 32.5 хувь нь согтуугаар, 13 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 66 буюу 12.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 22 буюу 4.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас,54 буюу 9.8 хувь бүлэглэн, 2 буюу 0.4 хувь нь галт зэвсгээр үйлдэгдсэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Дорноговь аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 236 буюу 42.9 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 60.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.9 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 1.8 нэгжээр өндөр байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 486 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 21 хэрэг буюу 4.5 хувиар, үүнээс 294 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 17 буюу 6.1 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 381 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37 буюу 10.8 хувиар өссөн. Холбогдогчдын 53 буюу 13.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 15.9 хувиар буурч, 328 буюу 86.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 16.7 хувиар, 14 буюу 3.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2.0 дахин тус тус өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 506 хүн, 38 хуулийн этгээд хохирч, үүнээс 24 хүн нас барж, 222 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 98 буюу 24.0 хувиар, гэмтсэн хүн 72 буюу 48.0 хувиар тус тус өсч, нас барсан хүн 3 буюу 11.1 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол



Хүн, хуулийн этгээдэд учирсан 3558.9 сая төгрөгийн хохирлын 55.4 хувийг нөхөн төлүүлж, 399.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 1257.8 буюу 54.7, нөхөн төлүүлсэн хохирол 1244.0 буюу 2.7 дахин тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 6466.8 буюу 94.2 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил

Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 33.016 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 13.345 буюу 67.8 хувиар, 32.992 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 13.406 буюу 68.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 31.824 буюу 96.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 113 буюу 0.3 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 99 буюу 0.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 980 буюу 3.0 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 32.002 хүн, 5 хуулийн этгээдийг 1484.2 сая төгрөгөөр торгох, 284 хүнийг баривчлах, 701 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 13.339 буюу 71.5 хувиар, баривчилсан шийтгэл 6 буюу 2.2 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 64 буюу 10.0 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Дорноговь аймагт нийт 1569 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 114 буюу 7.8 хувиар өссөн байна.

---oooOooo---

ДОРНОД АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Дорнод аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 4631 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1433 буюу 30.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3198 буюу 69.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 85 буюу 1.8 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 357 буюу 10.0 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 272 буюу 23.4 хувиар өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 605 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 3 буюу 0.5 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт 5.4 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 563, сард 47, хоногт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Баяндун сум	14	20	6	42.9	8	Сэргэлэн сум	15	13	-2	-13.3
2	Баянтүмэн сум	40	40	0	0.0	9	Халх гол сум	16	15	-1	-6.3
3	БаянУул сум	31	28	-3	-9.7	10	Хөлөнбуйр сум	16	18	2	12.5
4	Булган сум	32	36	4	12.5	11	Хэрлэн сум	322	318	-4	-1.2
5	Гурван загал сум	16	17	1	6.25	12	Цагаан-Овоо сум	24	40	16	66.7
6	Дашбалбар сум	16	19	3	18.8	13	Чойбалсан сум	27	12	-15	-55.6
7	Матад сум	20	21	1	5.0	14	Чулуунхороот сум		8		

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 490 буюу 81.0 хувь нь хөнгөн, 115 буюу 19.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 7.9 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 22.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	29	10	-65.5	1.7
	Үүнээс: Хүнийг алах	9	9	0.0	1.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	177	188	6.2	31.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	8	2	-75.0	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	19	18	-5.3	3.0
	Үүнээс: Хүчиндэх	16	17	6.3	2.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	2	3	50.0	0.5
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.2
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	280	294	5.0	48.6
	Үүнээс: Хулгайлах	124	91	-26.6	15.0
	Залилах	27	41	51.9	6.8
	Дээрэмдэх	4	6	50.0	1.0
	Мал хулгайлах	101	133	31.7	22.0
7	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	5	4	-20.0	0.7
8	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	7	1	-85.7	0.2
9	Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг	9	8	-11.1	1.3
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	3	3.0 дах	0.5
11	Авлигын эсрэг гэмт хэрэг	6	11	83.3	1.8
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3	3	0.0	0.5
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг	9	17	88.9	2.8
14	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		2		0.2
15	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	52	42	-19.2	6.9
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	52	42	-19.2	6.9
	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1			

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 1 буюу 1.1, мягмар гарагт 7 буюу 8.3, даваа гарагт 12 буюу 15.8 хувиар тус тус өсч, , пүрэв гарагт үйлдэгдсэн хэрэг 1 буюу 1.1, бямба гарагт 2 буюу 2.3, баасан гарагт 6 буюу 6.5, ням гарагт 8 буюу 10.4 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 25 буюу 17.2, 14-19 цагийн хооронд 1 буюу 0.6, 22-06 цагийн хооронд 24 буюу 10.8 хувиар тус тус буурч, 19-22 цагийн хооронд 53 буюу 67.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад газарт үйлдэгдсэн хэрэг 23 буюу 10.2, авто замд 10 буюу 30.3, төрийн байгууллагад 4 буюу 33.3, олон нийтийн газарт 16 буюу 45.7 хувиар тус тус өсч, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн хэрэг 5 буюу 16.1, гудамж талбайд 7 буюу 10.4, гэр орон сууцанд 37 буюу 19.3 хувиар тус тус буурч, төрийн бус байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны түвшинд байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 156 буюу 25.8 хувь нь согтуугаар, 11 буюу 1.8 хувь нь хүүхэд оролцож, 51 буюу 8.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 30 буюу 5.0 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 28 буюу 4.6 хувь нь бүлэглэн үйлдсэн, 1 буюу 0.2 хувь нь галт зэвсгээр үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Дорнод аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 249 буюу 41.2 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 58.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.9 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй ижил байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 511 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 46 хэрэг буюу 9.9 хувиар, үүнээс 300 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 45 буюу 17.6 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 414 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17 буюу 4.3 хувиар өссөн. Холбогдогчдын 375 буюу 90.6 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.6 хувиар, 39 буюу 9.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 11.4 хувиар тус тус өсч, 11 буюу 2.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.4 хувиар буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





.

Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 604 хүн, 3 хуулийн этгээд хохирч, үүнээс 31 хүн нас барж, 224 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 16 буюу 2.7, гэмтсэн хүн 5 буюу 2.3 хувиар тус тус өсч, нас барсан хүн 13 буюу 29.5 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол

Хүн, хуулийн этгээдэд учирсан 3988.6 сая төгрөгийн хохирлын 48.1 хувийг нөхөн төлүүлж, 178.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 866.7 буюу 27.8 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 1093.9 буюу 2.3 дахин тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 104.6 буюу 36.9 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил

Дорнод аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 20002 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1804 буюу 9.9 хувиар, 19800 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1794 буюу 10.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 18923 буюу 94.6 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 554 буюу 2.8 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 149 буюу 0.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 376 буюу 1.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 18903 хүн, 1 хуудийн этгээдийг 727.7 сая төгрөгөөр торгох, 311 хүнийг баривчлах, 585 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 1868 буюу 11.0 хувиар, баривчилах шийтгэл 76 буюу 32.3 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 147 буюу 20.1 хувиар буурсан байна.

2019 онд Дорнод аймагт нийт 4161 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 850 буюу 25.7 хувиар өссөн байна.

ДУНДГОВЬ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Дундговь аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 1872 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 657 буюу 35.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1215 буюу 64.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 196 буюу 11.7, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 2 буюу 0.3, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 194 буюу 19.0 хувиар тус тус өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 211 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 55 буюу 20.7 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 1.9 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 234, сард 19, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Адаацаг сум	14	11	-3	-21.4	10	Өндөршил сум	3	4	1	33.3
2	Баянжаргалан сум	10	4	-6	-60.0	11	Сайнцагаан сум	114	103	-11	-9.6
3	Говьугтаал сум	12	7	-5	-41.7	12	Сайхан овоо сум	3	3	0	0.0
4	Гурвансайхан сум	15	9	-6	-40.0	13	Хулд сум	22	8	-14	-63.6
5	Дэлгэрхангай сум	13	9	-4	-30.8	14	Цагаандэлгэр сум	5	10	5	2.0 дах
6	Дэлгэрцогт сум	14	9	-5	-35.7	15	Эрдэнэдалай сум	16	7	-9	-56.3
7	Дэрэн сум	10	11	1	10.0						
8	Луус сум	12	9	-3	-25.0						
9	Өлзийт сум	3	7	4	2.3 дах						

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 170 буюу 80.6 хувь нь хөнгөн, 41 буюу 19.4 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 1.8 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 58.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он

1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	5	1	-80.0	0.5
	Үүнээс: Хүнийг алах	4			
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	77	60	-22.1	28.4
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1	2	2.0 дах	0.9
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7	7	0.0	3.3
	Үүнээс: Хүчиндэх	4	5	25.0	2.4
4	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		1		0.5
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		1		0.5
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	144	111	-22.9	52.6
	Үүнээс: Хулгайлах	105	57	-45.7	27.0
	Залилах	10	17	70.0	8.1
	Дээрэмдэх	2	1	-50.0	0.5
	Мал хулгайлах	21	29	38.1	13.7
7	Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг	1			
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2			
9	Авлигын эсрэг гэмт хэрэг	10	7	-30.0	3.3
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	4	0.0	1.9
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг		5		2.4
12	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	16	14	-12.5	6.6
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	16	14	-12.5	6.6

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад баасан гарагт үйлдэгдсэн гэмт хэрэг 5 буюу 17.9 хувиар өсч, лхагва гарагт үйлдэгдсэн хэрэг 6 буюу 15.4, ням гарагт 6 буюу 18.8, пүрэв гарагт 8 буюу 22.2, бямба гарагт 9 буюу 22.5, мягмар гарагт 15 буюу 29.4, даваа гарагт 16 буюу 40.0 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 1 буюу 2.0 хувиар өсч, 14-19 цагийн хооронд 20 буюу 26.3, 19-22 цагийн хооронд 18 буюу 40.0, 22-06 цагийн хооронд 18 буюу 18.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад газарт үйлдэгдсэн хэрэг 3 буюу 3.8 хувиар, төрийн бус байгууллагад 4 буюу 5.0 дахин тус тус өсч, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн хэрэг 1 буюу 9.1, төрийн байгууллагад 4 буюу 25.0, гудамж талбайд 7 буюу 30.4, гэр орон сууцанд 41 буюу 37.6, олон нийтийн газарт 9 буюу 64.3, хувиар тус тус буурч, авто замд өмнөх оны түвшинд байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 55 буюу 26.1 хувь нь согтуугаар, 17 буюу 8.1 хувь нь хүүхэд оролцож, 18 буюу 8.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 9 буюу 4.3 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 14 буюу 6.6 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Дундговь аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 113 буюу 53.6 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 59.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.5 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 0.3 нэгжээр их байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 200 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 40 хэрэг буюу 16.7 хувиар, үүнээс 118 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 20 буюу 14.5 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 130 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 53 буюу 29.0 хувиар буурсан. Холбогдогчдын 119 буюу 91.5 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 31.6 хувиар буурч, 11 буюу 8.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 22.2 хувиар, 20 буюу 15.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.1 хувиар тус тус өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 209 хүн, 1 хуулийн этгээд хохирч, үүнээс 4 хүн нас барж, 76 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 49 буюу 19.0, нас барсан хүн 12 буюу 75.0, гэмтсэн хүн 9 буюу 10.6 хувиар тус тус буурсан байна.



4.2. Учирсан хохирол



Хүн, хуулийн этгээдэд учирсан 683.7 сая төгрөгийн хохирлын 41.4 хувийг нөхөн төлүүлж, 40.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 212.4 буюу 23.7, нөхөн төлүүлсэн хохирол 41.9 буюу 12.9, битүүмжилсэн хөрөнгө 17 буюу 29.8 хувиар тус тус буурсан байна.

Тав. Зөрчил

Дундговь аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 21591 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3864 буюу 21.8 хувиар, 21608 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3907 буюу 22.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 18967 буюу 87.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 2156 буюу 10.0 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 32 буюу 0.1 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 436 буюу 2.0 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 21255 хүн, 2 хуулийн этгээдийг 668.2 сая төгрөгөөр торгох, 112 хүнийг баривчлах, 239 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 3882 буюу 22.3 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 50 буюу 26.5 хувиар тус тус өсч, баривчилсан шийтгэл 27 буюу 19.4 хувиар буурсан байна.

2019 онд Дундговь аймагт нийт 732 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 125 буюу 20.6 хувиар өссөн байна.

---oooOooo---

ЗАВХАН АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Завхан аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 959 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 388 буюу 40.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 571 буюу 59.5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 6 буюу 0.6, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 59 буюу 17.9 хувиар тус тус өсч, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 53 буюу 8.5 хувиар буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 247 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 12 буюу 5.1 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.2 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 277, сард 23, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алдархаансум	19	20	1	5.3	13	Тосонцэнгэл сум	33	39	6	18.2
2	Асгат сум	3	1	-2	-66.7	14	Түдэвтэй сум	4	3	-1	-25.0
3	Баянтэс сум	2	8	6	4.0 дах	15	Тэлмэн сум	15	5	-10	-66.7
4	Баянхайрхан сум	3	2	-1	-33.3	16	Тэс сум	1	6	5	6.0 дах
5	Дөрвөлжинсум	7	15	8	2.1 дах	17	Улиастай сум	56	65	9	16.1
6	Завханмандал сум	10	6	-4	-40.0	18	Ургамал сум	4	1	-3	-75.0
7	Идэрсум	12	9	-3	-25.0	19	Цагаанхайрхан сум	7	5	-2	-28.6
8	Их-Уул сум	16	14	-2	-12.5	20	Цагаанчулуут сум		3	3	
9	Нөмрөг сум	1	1			21	Цэцэн уул сум	3	6	3	2.0 дах
10	Отгон сум	9	12	3	33.3	22	Шилүүстэй сум	5	4	-1	-20.0
11	Сантмаргац сум	10	7	-3	-30.0	23	Эрдэнэхайрхан сум	4	4		
12	Сонгино сум	7	6	-1	-14.3	24	Яруу сум	4	5	1	25.0

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 183 буюу 74.1 хувь нь хөнгөн, 64 буюу 25.9 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 8.9 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 4.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	5	5		2.0
	Үүнээс: Хүнийг алах	2	3	50	1.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	73	80	9.6	32.4
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3	5	66.7	2.0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	9	4.5 дах	3.6
	Үүнээс: Хүчиндэх	2	8	4.0 дах	3.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1			
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		1		0.4
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	106	108	1.9	43.7
	Үүнээс: Хулгайлах	60	42	30.0	17.0
	Залилах	3	15	5.0 дах	6.1
	Дээрэмдэх	1			
	Мал хулгайлах	31	42	35.5	17.0
7	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.4
8	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		2		0.8
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1			
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг		1		0.4
11	Авлигын эсрэг гэмт хэрэг	14	8	-42.9	3.2
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	5	7	40.0	2.8
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг	12	17	41.7	6.9
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	14	8	-42.9	3.4
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	14	8	-42.9	3.2

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад пүрэв гарагт үйлдэгдсэн хэрэг 3 буюу 13.0, лхагва гарагт 5 буюу 14.3, бямба гарагт 4 буюу 14.8, ням гарагт 18 буюу 81.8 хувиар тус тус өсч, мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 4 буюу 8.9, даваа гарагт 6 буюу 12.5, баасан гарагт 8 буюу 22.9 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06 -14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 10 буюу 21.3, 22-06 цагийн хооронд 8 буюу 9.4 хувиар тус тус өсч, 14-19 цагийн хооронд 2 буюу 2.8 хувиар, 19-22 цагийн хооронд 4 буюу 12.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 2 буюу 2.6, бусад газарт 22 буюу 29.3, гудамж талбайд 6 буюу 37.5 хувиар тус тус өсч, олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг 3 буюу 18.8, төрийн байгууллагад 3 буюу 18.8, аж ахуйн нэгж, байгууллагад 6 буюу 31.6, авто замд 6 буюу 40.0 хувиар тус тус буурч, төрийн бус байгууллагад мөн үеийн түвшинд байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 78 буюу 31.6 хувь нь согтуугаар, 10 буюу 4.0 хувь нь хүүхэд оролцож, 14 буюу 5.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 17 буюу 6.9 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 16 буюу 6.5 хувь нь бүлэглэн, 1 буюу 0.4 хувь нь галт зэвсгээр үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Завхан аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 122 буюу 49.4 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 67.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.1 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 9.2 нэгжээр өндөр байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 212 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 19 хэрэг буюу 9.8 хувиар, үүнээс 144 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 15 буюу 11.6 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 192 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 буюу 1.0 хувиар буурсан. Холбогдогчдын 10 буюу 5.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.0 дахин өсч,182 буюу 94.8 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.7 хувиар, 11 буюу 5.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.3 хувиар тус тус буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн

Гэмт хэргийн улмаас 247 хүн хохирч, үүнээс 13 хүн нас барж, 80 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал, хохирсон хүн 3 буюу 1.2, гэмтсэн хүн 8 буюу 9.1 хувиар тус тус буурч, нас барсан хүн өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.



4.2. Учирсан хохирол



Хүнд учирсан 677.6 сая төгрөгийн хохирлын 46.3 хувийг нөхөн төлүүлж, 324.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 279.5 буюу 29.2, нөхөн төлүүлсэн хохирол 95.0 буюу 23.3, битүүмжилсэн хөрөнгө 11.8 буюу 3.5 хувиар тус тус буурсан байна.

Тав. Зөрчил

Завхан аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 17.635 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал 8.022 буюу 2.2, 17.604 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал 8.044 буюу 2.2 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 16.975 буюу 96.3 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 218 буюу 1.2 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 56 буюу 0.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 386 буюу 2.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 16.917 иргэнийг 638.4 сая төгрөгөөр торгох, 288 хүнийг баривчлах, 399 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 7831 буюу 86.2 хувиар, баривчилсан шийтгэл 91 буюу 46.2 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 122 буюу 44.0 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Завхан аймагт нийт 459 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 180 буюу 28.2 хувиар буурсан байна.

ОРХОН АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Орхон аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 6304 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1146 буюу 18.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 5158 буюу 81.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 441 буюу 6.5, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 458 буюу 8.2 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 17 буюу 1.5 хувиар өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 747 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 47 буюу 5.9 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.7 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 621, сард 52 г, хоногт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/

1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/

Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баян-Өндөр сум	773	724	-49	-6.3
2	Жаргалант сум	21	23	2	9.5

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 539 буюу 72.2 хувь нь хөнгөн, 208 буюу 27.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 6.1 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 27.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	10	21	2.1 дах	2.8
	Үүнээс: Хүнийг алах	8	3	-62.5	0.4
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	221	195	-11.8	26.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	8	4.0 дах	1.1
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	43	17	-60.5	2.3
	Үүнээс: Хүчиндэх	22	17	-22.7	2.3
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		1		0.1
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		1		0.1
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	438	405	-7.5	54.2
	Үүнээс: Хулгайлах	297	226	-23.9	30.3
	Залилах	83	114	37.3	15.3
	Дээрэмдэх	27	8	-70.4	1.1
	Мал хулгайлах	7	8	14.3	1.1
7	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	2	4	2.0 дах	0.5
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	23	32	39.1	4.3
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	6	12	2.0 дах	1.7
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	20	19	-5.0	2.5
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2	10	5.0 дах	1.3
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг	1	3	3.0 дах	0.4
13	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	28	27	-3.6	3.7
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	28	27	-3.6	3.7

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад пүрэв гарагт үйлдэгдсэн хэрэг 14 буюу 12.8 хувиар өсч, даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 3 буюу 2.6, лхагва гараигт 7 буюу 5.7, бямба гарагт 8 буюу 7.8, мягмар гарагт 10 буюу 8.8, баасан гарагт 12 буюу 9.2, ням гарагт 21 буюу 20.8 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06 -14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 15 буюу 9.5, 14-19 цагийн хооронд 14 буюу 6.2 хувиар тус тус өсч, 19-22 цагийн хооронд 26 буюу 19.7, 22-06 цагийн хооронд 50 буюу 18.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг 2 буюу 1.7, аж ахуйн нэгжид 9 буюу 12.7, нийтийн тээвэр 1 буюу 25.0 хувиар тус тус өсч, олон нийтийн газар 1 буюу 1.4, төрийн байгууллагад 1 буюу 3.4, авто замд 1 буюу 3.6, гэр орон сууцанд 36 буюу 9.3, бусад газар 18 буюу 23.4, төрийн бус байгууллагад 2 буюу 28.6 хувиар тус тус буурсан байна.



Гэр, орон сууц 47.1% | Гудамж, талбай 16.1% | Олон нийтийн газар 9.5% | Аж ахуйн нэгж 7.9% | Авто зам 3.6% | Бусад газар 15.8%

1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 207 буюу 27.7 хувь нь согтуугаар, 37 буюу 5.0 хувь нь хүүхэд оролцож, 110 буюу 14.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 17 буюу 2.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 62 буюу 8.3 хувь нь бүлэглэн, 23 буюу 3.1 хувь нь мансуурсан үедээ үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Орхон аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 319 буюу 42.7 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 60.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.3 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 1.5 нэгжээр өндөр байна.



2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 704 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 15 хэрэг буюу 2.2 хувиар, үүнээс 424 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 25 буюу 6.3 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 511 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29 буюу 5.4 хувиар буурсан.

Холбогдогчдын 424 буюу 83.0 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 5.8 хувиар, 87 буюу 17.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.3 хувиар тус тус буурч, 47 буюу 9.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56.7 хувиар өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 686 хүн, 1 хуулийн этгээд хохирч, үүнээс 27 хүн нас барж, 232 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 15 буюу 2.3 дахин өсч, хохирсон хүн 70 буюу 9.3, гэмтсэн хүн 37 буюу 13.8 хувиар тус тус буурсан байна.



4.2 Учирсан хохирол



Хүн, хуулийн этгээдэд учирсан 2610.9 сая төгрөгийн хохирлын 36.5 хувийг нөхөн төлүүлж, 55.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 1032.5 буюу 65.4, нөхөн төлүүлсэн хохирол 55.5 буюу 6.2 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 47.0 буюу 45.9 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил

Орхон аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 31.660 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7869 буюу 33.1 хувиар, 31591 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7958 буюу 33.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 29.367 буюу 92.8 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 110 буюу 0.3 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 272 буюу 0.9 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1911 буюу 6.0 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 29.102 хүн, 21 хуулийн этгээдийг 177.7 сая төгрөгөөр торгох, 922 хүнийг баривчлах, 1546 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгох шийтгэл 7789 буюу 36.5 хувиар, баривчилсан шийтгэл 113 буюу 14.0 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 41 буюу 2.7 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Орхон аймагт нийт 3197 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 375 буюу 10.5 хувиар буурсан байна.

---oooOooo---

ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 4721 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 886 буюу 18.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3835 буюу 81.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 1053 буюу 28.7, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 1189 буюу 44.9 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 136 буюу 13.3 хувиар буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 613 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 57 буюу 8.5 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 5.5 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 529, сард 44, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Арвайхээр сум	304	298	-6	-2.0
2	Баруунбаян-Улаан сум	8	12	4	50.0
3	Батөлзий сум	55	38	-17	-30.9
4	Баянгол сум	12	2	-10	-83.3
5	Баянөндөр сум	7	8	1	14.3
6	Богд сум	28	17	-11	-39.3
7	Бүрд сум	14	9	-5	-35.7
8	Гучин ус сум	17	12	-5	-29.4
9	Есөнзүйл сум	15	6	-9	-60.0
10	Зүүнбаянулаан сум	16	16	0	
11	Нарийн тээл сум	19	16	-3	-15.8
12	Өлзийт сум	1	4	3	4.0 дах
13	Сант сум	5	7	2	40.0
14	Тарагт сум	22	18	-4	-18.2
15	Төгрөг сум	4	7	3	75.0
16	Уянга сум	29	24	-5	-17.2
17	Хайрхан дулаан сум	20	18	-2	-10.0
18	Хархорин сум	69	73	4	5.8
19	Хужирт сум	25	28	3	12.0

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 457 буюу 74.6 хувь нь хөнгөн, 156 буюу 25.4 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 7.7 хувиар, хүнд гэмт хэрэг 10.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	17	11	-35.3	1.8
	Үүнээс: Хүнийг алах	2	3	50.0	0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	233	180	-22.8	29.4
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	16	6	-62.5	1.0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	16	27	68.8	4.4
	Үүнээс: Хүчиндэх	13	6	-53.8	1.0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1			
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		2		0.3
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	307	324	5.5	52.8
	Үүнээс: Хулгайлах	224	199	-11.2	32.5
	Залилах	27	28	3.7	4.6
	Дээрэмдэх	4	11	2.8 дах	1.8
	Мал хулгайлах	37	57	54.1	9.3
7	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.3
	Эдийн засгийн гэмт хэрэг	1			
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	6	4	-33.3	0.7
9	Авлигын эсрэг гэмт хэрэг	3	6	2.0 дах	1.0
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2	4	2.0 дах	0.7
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг	33	26	-21.2	4.2
12	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	50	27	-46.0	4.4
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	50	26	-48.0	4.2

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад баасан гарагт үйлдэгдсэн хэрэг 7 буюу 7.8, даваа гарагт 11 буюу 9.5 хувиар тус тус өсч, мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 4 буюу 3.8, лхагва гарагт 7 буюу 6.9, пүрэв гарагт 14 буюу 17.1, бямба гарагт 23 буюу 28.0, ням гарагт 27 буюу 29.0 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 1 буюу 0.7, 14-19 цагийн хооронд 36 буюу 19.1, 19-22 цагийн хооронд 2 буюу 1.8, 22-06 цагийн хооронд 18 буюу 7.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрийн байгууллагад үйлдэгдсэн хэрэг 1 буюу 6.3, олон нийтийн газарт 18 буюу 45.0 хувиар, төрийн бус байгууллагад 3 буюу 4.0 дахин тус тус өсч, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 16 буюу 5.7, гудамж талбайд 9 буюу

14.3, бусад газарт 35 буюу 17.2, аж ахуйн нэгж, байгууллагад 5 буюу 22.7, авто замд 13 буюу 31.7 хувиар тус тус буурсан байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 154 буюу 25.1 хувь нь согтуугаар, 11 буюу 1.8 хувь нь хүүхэд оролцож, 42 буюу 6.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 35 буюу 5.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 56 буюу 9.1 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Өвөрхангай аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 327 буюу 53.3 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 49.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.5 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 9.2 нэгжээр бага байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 566 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 31 хэрэг буюу 5.2 хувиар, үүнээс 280 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 30 буюу 9.7 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 421 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71 буюу 14.4 хувиар буурсан. Холбогдогчдын 391 буюу 92.9 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 13.9 хувиар, 30 буюу 7.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 21.1 хувиар, 20 буюу 4.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.7 хувиар тус тус буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн

Гэмт хэргийн улмаас 618 хүн хохирч, үүнээс 21 хүн нас барж, 208 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 56 буюу 8.3, нас барсан хүн 14 буюу 40.0, гэмтсэн хүн 45 буюу 17.8 хувиар тус тус буурсан байна.



4.2. Учирсан хохирол

Хүнд учирсан 1060.2 сая төгрөгийн хохирлын 23.7 хувийг нөхөн төлүүлж, 134.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 122.6 буюу 10.4 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 184.7 буюу 42.4, битүүмжилсэн хөрөнгө 241.5 буюу 64.2 хувиар тус тус буурсан байна.

Тав. Зөрчил

Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 43.498 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 18.593 буюу 74.7 хувиар, 43.264 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 18.696 буюу 76.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 40.816 буюу 93.8 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1714 буюу 3.9 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 115 буюу 0.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 853 буюу 2.0 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 40.904 иргэнийг 1324.7 сая төгрөгөөр торгох, 1286 хүнийг баривчлах, 1074 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 18.239 буюу 80.5 хувиар, баривчилсан шийтгэл 305 буюу 31.1 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 153 буюу 16.6 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Өвөрхангай аймагт нийт 1157 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 673 буюу 2.4 дахин өссөн байна.

---oooOooo---

ӨМНӨГОВЬ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 3264 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 949 буюу 29.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2315 буюу 70.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 438 буюу 15.5, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 101 буюу 11.9, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 337 буюу 17.0 хувиар тус тус өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 515 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 86 буюу 20.0 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.6 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 406, сард 34, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Баяндалай сум	7	8	1	14.3	9	Номгон сум	5	8	3	60.0
2	Баяновоо сум	12	11	-1	-8.3	10	Сэврэй сум	5	6	1	20.0
3	Булган сум	9	8	-1	-11.1	11	Ханбогд сум	125	148	23	18.4
4	Гурвантэс сум	36	39	3	8.3	12	Ханхонгор сум	17	17	0	0.0
5	Даланзадгад сум	111	136	25	22.5	13	Хүрмэн сум	4	6	2	50.0
6	Мандал овоо сум	2	3	1	50.0	14	Цогт овоо сум	15	11	-4	-26.7
7	Манлай сум	6	18	12	3.0 дах	15	Цогтцэций сум	71	92	21	29.6
8	Ноён сум	4	4	0	0.0						

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 421 буюу 81.7 хувь нь хөнгөн, 94 буюу 18.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 16.9, хүнд гэмт хэрэг 36.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	13	14	7.7	2.7
	Үүнээс: Хүнийг алах	6	5	-16.7	1.0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	182	177	-2.7	34.4
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	7			
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	11	21	90.9	4.1
	Үүнээс: Хүчиндэх	11	12	9.1	2.3
4	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	2			
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	134	169	26.1	32.9
	Үүнээс: Хулгайлах	63	91	44.4	17.7
	Залилах	27	29	7.4	5.6
	Дээрэмдэх	2	2	0.0	0.4
	Мал хулгайлах	8	13	62.5	2.5
6	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	18	29	61.1	5.6
7	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1		0.2
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3	9	3.0 дах	1.7
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг		2		0.4
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	6	10	66.7	1.9
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	5	7	40.0	1.4
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг	6	12	2.0 дах	2.3
13	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	49	62	26.5	12.0
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	48	61	27.1	11.8
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг		1		0.2

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бямба гарагт үйлдэгдсэн хэрэг 1 буюу 1.5, лхагва гарагт 2 буюу 3.1, ням гарагт 8 буюу 12.9, пүрэв гарагт 15 буюу 24.2, даваа гарагт 18 буюу 27.3, мягмар гарагт 17 буюу 37.8, баасан гарагт 25 буюу 40.3 хувиар тус тус өссөн байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 30 буюу 30.6, 19-22 цагийн хооронд 32 буюу 60.4, 22-06 цагийн хооронд 32 буюу 21.3 хувиар тус тус өсч, 14-19 цагийн хооронд үйлдэгдсэн гэмт хэрэг 8 буюу 6.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.





1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 16 буюу 11.7, гудамж талбайд 13 буюу 23.6, авто замд 16 буюу 30.8, бусад газарт 37 буюу 32.5, төрийн байгууллагад 11 буюу 78.6 хувиар, төрийн бус байгууллагад 3 буюу 2.0 дахин тус тус өсч, олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг 2 буюу 9.5, аж ахуйн нэгжид 7 буюу 21.9 хувиар тус тус буурсан байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 146 буюу 28.3 хувь нь согтуугаар, 10 буюу 1.9 хувийг хүүхэд оролцож, 54 буюу 10.5 хувийг эмэгтэй хүн оролцсон, 21 буюу 4.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 56 буюу 10.9 хувийг бүлэглэн, 9 буюу 1.7 хувь нь галт зэвсгээр тус тус үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Өмнөговь аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 203 буюу 39.4 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 57.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 7.4 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 1.5 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 439 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 120 хэрэг буюу 37.6 хувиар өсч, үүнээс 251 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 45 буюу 21.8 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 379 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 буюу 0.5 хувиар буурсан. Холбогдогчдын 45 буюу 11.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 12.5 хувиар, 14 буюу 3.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин өссөн байна. 334 буюу 88.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.1 хувиар буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 540 хүн, 1 хуулийн этгээд хохирч, үүнээс 34 хүн нас барж, 253 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал, хохирсон хүн 106 буюу 24.4, нас барсан хүн 6 буюу 21.4, гэмтсэн хүн 2 буюу 0.8 хувиар тус тус өссөн байна.



4.2. Учирсан хохирол



/сая төг-өөр/

Хүн, хуулийн этгээдэд учирсан 1574.5 сая төгрөгийн хохирлын 76.2 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 703.2 буюу 30.9 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 352.7 буюу 41.7 хувиар өссөн байна.

Тав. Зөрчил

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 19.311 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал 20.908 буюу 52.0, 19.206 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал 20.907 буюу 52.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 17.928 буюу 92.8 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 82 буюу 0.4 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 35 буюу 0.2 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1266 буюу 6.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 18.250 хүнийг 1115.7 сая төгрөгөөр торгох, 203 хүнийг баривчлах, 748 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 20.769 буюу 53.2, баривчилсан шийтгэл 71 буюу 25.9, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 56 буюу 7.0 хувиар тус тус буурсан байна.

2019 онд Өмнөговь аймагт нийт 1420 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 890 буюу 2.7 дахин өссөн байна.

СҮХБААТАР АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 2380 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1005 буюу 42.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1375 буюу 57.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 37 буюу 1.5 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 204 буюу 12.9 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 167 буюу 19.9 хувиар өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 525 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 159 буюу 43.4 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.7 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 308, сард 26, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Асгат сум	12	12			8	Сүхбаатар сум	26	39	13	50.0
2	Баруун урт сум	162	189	27	16.7	9	Түвшинширээ сум	19	20	1	5.3
3	Баяндэлгэр сум	8	21	13	2.6 дах	10	Түмэнцогт сум	9	26	17	2.9 дах
4	Дарьганга сум	8	27	19	3.4 дах	11	Уулбаян сум	32	44	12	37.5
5	Мөнххаан сум	43	50	7	16.3	12	Халзан сум	6	8	2	33.3
6	Наран сум	7	12	5	71.4	13	Эрдэнэцагаан сум	25	71	46	2.3 дах
7	Онгон сум	9	6	-3	-33.3						

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 417 буюу 79.4 хувь нь хөнгөн, 108 буюу 20.6 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 38.1, хүнд гэмт хэрэг 68.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	13	8	-38.5	1.5
	Үүнээс: Хүнийг алах	5	1	-80.0	0.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	133	115	-13.5	21.9
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3	1	-66.7	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	11	15	36.4	2.9
	Үүнээс: Хүчиндэх	11	14	27.3	2.7
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		2		0.4
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	165	314	90.3	59.8
	Үүнээс: Хулгайлах	61	104	70.5	19.8
	Залилах	27	33	22.2	6.3
	Дээрэмдэх	2	4	2.0 дах	0.8
	Мал хулгайлах	68	149	2.2 дах	28.4
8	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	1	14	14.0 дах	2.7
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2	2		0.4
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	7	11	57.1	2.3
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3	4	33.3	0.8
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг	2	1	-50.0	0.2
13	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		3		0.6
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	28	34	21.4	6.5
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	27	33	22.2	6.3
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1			

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бямба гарагт үйлдэгдсэн хэрэг 7 буюу 12.1, даваа гарагт 15 буюу 24.6, мягмар гарагт 19 буюу 35.8, пүрэв гарагт 25 буюу 50.0, ням гарагт 26 буюу 56.5, баасан гарагт 31 буюу 59.6, лхагва гарагт 36 буюу 78.3 хувиар тус тус өсчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 37 буюу 52.9, 14-19 цагийн хооронд 68 буюу 79.1, 19-22 цагийн хооронд 32 буюу 57.1, 22-06 цагийн хооронд 22 буюу 14.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 13 буюу 10.2, төрийн бус байгууллагад 1 буюу 33.3, авто замд 9 буюу 34.6, олон нийтийн газарт 7 буюу 38.9, бусад газарт 90 буюу 61.2, төрийн байгууллагад 10 буюу 62.5, аж ахуйн нэгжид 8 буюу 66.7 хувиар, гудамж талбайд 20 буюу 2.2 дахин тус тус өсч, нийтийн тээвэрт 1 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.



Гэр, орон сууц 26.7% | Гудамж, талбай 7.0% | Олон нийтийн газар 4.8% | Аж ахуйн нэгж 3.8% | Авто зам 6.7% | Бусад газар 51.0%

1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 94 буюу 17.9 хувь нь согтуугаар, 10 буюу 1.9 хувь нь хүүхэд оролцож, 34 буюу 6.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 9 буюу 1.7 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 51 буюу 9.7 хувь нь бүлэглэн, 1 буюу 0.2 хувь нь галт зэвсгээр үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Сүхбаатар аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 313 буюу 59.6 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 48.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 13.9 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 10.5 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 436 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 120 хэрэг буюу 38.0 хувиар, үүнээс 210 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 14 буюу 7.1 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 346 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71 буюу 25.8 хувиар өссөн. Холбогдогчдын 328 буюу 94.8 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 22.8 хувиар, 18 буюу 5.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.2 дахин, 16 буюу 4.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 60.0 хувиар тус тус өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн

Гэмт хэргийн улмаас 533 хүн хохирч, үүнээс 17 хүн нас барж, 139 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 186 буюу 53.6 хувиар өсч, нас барсан хүн 5 буюу 22.7, гэмтсэн хүн 15 буюу 9.7 хувиар тус тус буурсан байна.



4.2. Учирсан хохирол



Хүнд учирсан 1492.4 сая төгрөгийн хохирлын 42.0 хувийг нөхөн төлүүлж, 70.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 689.2 буюу 85.8, нөхөн төлүүлсэн хохирол 153.0 буюу 32.3 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 14.6 буюу 17.1 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил

Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 9.438 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4.160 буюу 78.8 хувиар, 9389 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4259 буюу 83.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 8.687 буюу 92.0 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 287 буюу 3.0 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 79 буюу 0.8 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 385 буюу 4.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 8.862 хүн, 6 хуулийн этгээдийг 455.2 сая төгрөгөөр торгох, 160 хүнийг баривчлах, 361 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 4164 буюу 88.6 хувиар, баривчилсан шийтгэл 29 буюу 22.1 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 61 буюу 20.3 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Сүхбаатар аймагт нийт 540 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 буюу 1.8 хувиар буурсан байна.

---oooOooo---

СЭЛЭНГЭ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 3454 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1235 буюу 35.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2219 буюу 64.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 71 буюу 2.0, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 225 буюу 9.2 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 154 буюу 14.2 хувиар өссөн байна.

1.2. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 767 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 12 буюу 1.5 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.8 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 729, сард 61, хоногт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алтанбулаг сум	44	61	17	38.6	10	Сайхан сум	52	43	-9	-17.3
2	Баруун бүрэн сум	23	19	-4	-17.4	11	Сан сум	11	10	-1	-9.1
3	Баянгол сум	42	54	12	28.6	12	Сүхбаатар сум	177	137	-40	-22.6
4	Ерөө сум	68	64	-4	-5.9	13	Түшиг сум	14	10	-4	-28.6
5	Жавхлант сум	10	14	4	40.0	14	Хушаат сум	11	13	2	18.2
6	Зүүн бүрэн сум	15	14	-1	-6.7	15	Хүдэр сум	32	22	-10	-31.3
7	Мандал сум	204	218	14	6.9	16	Цагаан нуур сум	23	29	6	26.1
8	Орхон сум	16	15	-1	-6.3	17	Шаамар сум	23	22	-1	-4.3
9	Орхонтуул сум	14	22	8	57.1						

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 590 буюу 76.9 хувь нь хөнгөн, 177 буюу 23.1 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 6.8 хувиар буурч, хүнд гэмт хэрэг 21.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1.5 Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	27	21	-22.2	2.7
	Үүнээс: Хүнийг алах	10	8	-20.0	1.0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	248	184	-25.8	24.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	7	7		0.9
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	23	32	39.1	4.2
	Үүнээс: Хүчиндэх	18	24	33.3	3.1
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		2		0.3
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	285	330	15.8	43.0
	Хулгайлах	149	154	3.4	20.1
	Залилах	55	48	-12.7	6.3
	Дээрэмдэх	11	13	18.2	1.7
	Мал хулгайлах	37	66	78.4	8.6
6	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	1	9	9.0 дах	1.2
7	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7	1	-85.7	0.1
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	5	9	80.0	1.2
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	11	1	-90.9	0.1
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	17	17		2.2
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	9	9		1.2
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг	78	111	42.3	14.5
13	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		2		0.3
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	68	39	-42.6	5.0
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	67	39	-41.8	5.0

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 1 буюу 0.9, лхагва гарагт 12 буюу 11.5, пүрэв гарагт 26 буюу 27.4 хувиар тус тус өсч, баасан гарагт үйлдэгдсэн хэрэг 4 буюу 3.2, бямба гарагт 13 буюу 11.6, ням гарагт 34 буюу 28.1 хувиар тус тус буурч, даваа гарагт үйлдэгдсэн гэмт хэрэг урд оны мөн үеийн түвшинд байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 27 буюу 15.8 хувиар өсч, 14-19 цагийн хооронд 16 буюу 7.2, 19-22 цагийн хооронд 14 буюу 11.7, 22-06 цагийн хооронд 9 буюу 3.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад газарт үйлдэгдсэн хэрэг 67 буюу 29.4 хувиар, нийтийн тээвэрт 1 буюу 33.3, төрийн бус байгууллагад 3 буюу 2.5 дахин тус тус өсч, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 2 буюу 0.8, аж ахуйн нэгжид 7 буюу 17.9, гудамж талбайд 16 буюу 20.8, олон нийтийн газарт 21 буюу 28.0, төрийн байгууллагад 12 буюу 30.0, авто замд 25 буюу 36.8 хувиар тус тус буурсан байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 170 буюу 22.2 хувь нь согтуугаар, 37 буюу 4.8 хувь нь хүүхэд оролцож, 94 буюу 12.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 42 буюу 5.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 90 буюу 11.7 хувь нь бүлэглэн, 1 буюу 0.1 хувь нь галт зэвсгээр үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Сэлэнгэ аймагт бүртгэгдсэн нийт хэргийн 324 буюу 42.2 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 54.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.2 нэгжээр буурсан байна.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 4.2 нэгжээр бага байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 594 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9 хэрэг буюу 1.5 хувиар, үүнээс 324 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 12 буюу 3.6 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 558 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65 буюу 10.4 хувиар буурсан. Холбогдогчдын 487 буюу 87.3 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 7.4 хувиар, 71 буюу 12.7 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 26.8 хувиар, 54 буюу 9.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.5 хувиар тус тус буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1. Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 745 хүн, 3 хуулийн этгээд хохирч, үүнээс 37 хүн нас барж, 247 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 27 буюу 3.8 хувиар өсч, нас барсан хүн 11 буюу 22.9, гэмтсэн хүн 63 буюу 20.3 хувиар тус тус буурсан байна.



4.2. Учирсан хохирол



Хүн, хуулийн этгээдэд учирсан 2700.7 сая төгрөгийн хохирлын 41.6 хувийг нөхөн төлүүлж, 243.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 1050.9 буюу 63.7, нөхөн төлүүлсэн хохирол 262.0 буюу 30.5 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 99.7 буюу 29.0 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил

Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 26.499 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3063 буюу 13.1 хувиар, 26.368 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3031 буюу 13.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 24.552 буюу 92.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 999 буюу 3.8 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 166 буюу 0.6 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 782 буюу 2.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 25.143 иргэнийг 123.3 сая төгрөгөөр торгох, 398 хүнийг баривчлах, 827 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгох шийтгэл 2919 буюу 13.1 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 143 буюу 20.9 хувиар тус тус өсч, баривчилсан шийтгэл 29 буюу 6.8 хувиар буурсан байна.

2019 онд Сэлэнгэ аймагт нийт 1870 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 281 буюу 13.1 хувиар буурсан байна.

ТӨВ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Төв аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 4148 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1687 буюу 40.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2461 буюу 59.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 465 буюу 12.6, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 160 буюу 10.5, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 305 буюу 14.1 хувиар тус тус өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 865 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 86 буюу 11.0 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 7.7 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 807, сард 67, хоногт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алтанбулаг сум	21	27	6	28.6	15	Дэлгэрхаан сум	13	10	-3	-23.1
2	Архуст сум	37	9	-28	-75.7	16	Жаргалант сум	28	31	3	10.7
3	Аргалант сум	6	33	27	5.5 дах	17	Заамар сум	74	45	-29	-39.2
4	Батсүмбэр сум	39	44	5	12.8	18	Зуунмод сум	129	155	26	20.2
5	Баян сум	33	32	-1	-3.0	19	Лүн сум	17	24	7	41.2
6	Баяндэлгэр сум	24	15	-9	-37.5	20	Мөнгөнморьт сум	8	10	2	25.0
7	Баянжаргалан сум	10	10	0	0.0	21	Өндөрширээт сум	13	23	10	76.9
8	Баянөнжүүл сум	8	32	24	4.0 дах	22	Сүмбэр сум	14	9	-5	-35.7
9	Баянхангай сум	21	14	-7	-33.3	23	Сэргэлэн сум	64	89	25	39.1
10	Баянцагаан сум	12	28	16	2.3 дах	24	Угтаалцайдам сум	10	11	1	10.0
11	Баянцогт сум	15	21	6	40.0	25	Цээл сум	8	9	1	12.5
12	Баянчандмань сум	46	44	-2	-4.3	26	Эрдэнэ сум	47	64	17	36.2
13	Борнуур сум	40	43	3	7.5	27	Эрдэнэсант сум	36	23	-13	-36.1
14	Бүрэн сум	6	10	4	66.7						

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 714 буюу 82.5 хувь нь хөнгөн, 151 буюу 17.5 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 23.5 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 24.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	52	43	-17.3	5.0
	Үүнээс: Хүнийг алах	5	8	60.0	0.9
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	203	210	3.4	24.3
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	10	5	-50.0	0.6
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	16	8	-50.0	0.9
	Үүнээс: Хүчиндэх	16	7	-56.3	0.8
5	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.1
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	364	408	12.1	47.3
	Үүнээс: Хулгайлах	199	158	-20.6	18.3
	Залилах	24	17	-29.2	2.0
	Дээрэмдэх	2	1	-50.0	0.1
	Мал хулгайлах	114	199	74.6	23.0
7	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	1	7	7 дах	0.8
8	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	1			
9	Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг	7	15	2.1 дах	1.7
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	8	6	-25.0	0.7
11	Авлигын эсрэг гэмт хэрэг	12	15	25.0	1.7
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	7	5	-28.6	0.6
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг	21	26	23.8	3.0
14	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	-	1	-	0.1
15	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	85	117	37.6	13.5
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	84	116	38.1	13.4
16	Цэргийн албаны эсрэг	1	3	3 дах	0.3

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 25 буюу 20.0, лхагва гарагт 34 буюу 36.2, пүрэв гарагт 16 буюу 13.4, баасан гарагт 2 буюу 1.8, ням гарагт 21 буюу 23.1 хувиар тус тус өсч, мягмар гарагт 3 буюу 2.4, бямба гарагт 9 буюу 8.3 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 26 буюу 16.3, 14-19 цагийн хооронд 5 буюу 2.8, 19-22 цагийн хооронд 7 буюу 6.3, 22-06 цагийн хооронд 48 буюу 14.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрийн байгууллагад үйлдэгдсэн хэрэг 6 буюу 23.1, бусад газарт 123 буюу 41.0, авто замд 35 буюу 44.3, гудамж талбайд 1 буюу 1.5 хувиар тус тус өсч, гэр орон сууцанд 55 буюу 24.4, олон нийтийн газарт 6 буюу 17.6, төрийн бус байгууллагад 4 буюу 66.6, аж ахуйн нэгжид 12 буюу 38.7 хувиар тус тус буурчээ.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 114 буюу 13.1 хувь нь согтуугаар, 20 буюу 2.3 хувь нь хүүхэд оролцож, 71 буюу 8.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 33 буюу 3.8 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 110 буюу 12.7 хувь нь бүлэглэн, 2 буюу 0.2 хувь нь галт зэвсгээр үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Төв аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 384 буюу 44.4 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 53.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.6 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 5.7 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 773 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 134 хэрэг буюу 21.0 хувиар, үүнээс 410 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 75 буюу 22.4 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 551 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 буюу 4.4 хувиар өссөн. Холбогдогчдын 499 буюу 90.6 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.2, 52 буюу 9.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 48.5, 31 буюу 5.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 19.2 хувиар тус тус өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 863 хүн, 1 хуулийн этгээд хохирч, үүнээс 72 хүн нас барж, 283 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 98 буюу 12.8, гэмтсэн хүн 29 буюу 11.4 хувиар тус тус өсч, нас барсан хүн 15 буюу 17.2, хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол



Хүн, хуулийн этгээдэд учирсан 4153.6 сая төгрөгийн хохирлын 60.8 хувийг нөхөн төлүүлж, 1568.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 927.4 буюу 28.7, нөхөн төлүүлсэн хохирол 129.4 буюу 5.4 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 956.6 буюу 2.6 дахин тус тус өссөн байна.

Тав. Зөрчил

Төв аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 56902 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9873 буюу 21.0 хувиар, 56853 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9963 буюу 21.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 55417 буюу 97.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 346 буюу 0.6 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 336 буюу 0.6 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 803 буюу 1.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 55684 хүнийг 1800.4 сая төгрөгөөр торгох, 528 хүнийг баривчлах, 641 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 9673 буюу 21.0 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 258 буюу 67.4, баривчилсан шийтгэл 32 буюу 6.5 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Төв аймагт нийт 617 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 172 буюу 21.8 хувиар буурсан байна.

---oooOooo---

УВС АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Увс аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 1546 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 662 буюу 42.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 884 буюу 57.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 332 буюу 27.3, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 128 буюу 24.0, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 204 буюу 30.0 хувиар тус тус өссөн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 327 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 5 буюу 1.5 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.9 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 346, сард 29, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Баруунтуруун сум	7	3	-4	-57.1	11	Өндөрхангай сум	14	13	-1	-7.1
2	Бөхмөрөн сум	10				12	Сагил сум	18	7	-11	-61.1
3	Давст сум	15	11	-4	-26.7	13	Тариалан сум	11	17	6	54.5
4	Завхан сум	2				14	Түргэн сум	13	20	7	53.8
5	Зүүнговь сум	6	6	0	0.0	15	Тэс сум	8	14	6	75.0
6	Зүүнхангай сум	1	12	11	12.0 дах	16	Улаангом сум	182	163	-19	-10.4
7	Малчин сум	8	12	4	50.0	17	Ховд сум	4	6	2	50.0
8	Наранбулаг сум	15	18	3	20.0	18	Хяргас сум	5	6	1	20.0
9	Өлгий сум	2	5	3	2.5 дах	19	Цагаанхайрхан сум	3	4	1	33.3
10	Өмнөговь сум	8	10	2	25.0						

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 265 буюу 81.0 хувь нь хөнгөн, 62 буюу 19.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 1.9 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 13.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	3	5	66.7	1.5
	Үүнээс: Хүнийг алах	1	3	3.0 дах	0.9
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	117	118	0.9	36.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1	2	2.0 дах	0.6
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	14	21	50.0	6.4
	Үүнээс: Хүчиндэх	13	19	46.2	5.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1			
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.3
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	136	143	5.1	43.7
	Үүнээс: Хулгайлах	70	57	-18.6	17.4
	Залилах	7	7		2.1
	Дээрэмдэх	3	5	66.7	1.5
	Мал хулгайлах	48	53	10.4	16.2
7	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	4			
8	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	15	3	-80.0	0.9
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3			
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	13	13.0 дах	4.2
11	Авлигын эсрэг гэмт хэрэг	10	3	-70.0	0.9
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3	6	2.0 дах	1.8
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг	6	6		1.8
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	16	8	-50.0	2.4
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	16	7	-56.3	2.1
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1			

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 5 буюу 9.3, мягмар гарагт 6 буюу 14.0, лхагва гарагт 12 буюу 26.1 хувиар тус тус өсч, ням гарагт 1 буюу 2.4, бямба гарагт 9 буюу 23.7, баасан гарагт 18 буюу 28.6 хувиар тус тус буурч, пүрэв гарагт өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 1 буюу 1.4, 19-22 цагийн хооронд 2 буюу 3.4 хувиар тус тус өсч, 14-19 цагийн хооронд 1 буюу 1.2, 22-06 цагийн хооронд 7 буюу 5.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад газарт үйлдэгдсэн хэрэг 13 буюу 11.6, аж ахуйн нэгжид 3 буюу 25.0, төрийн байгууллагад 5 буюу 27.8, олон нийтийн газарт 4 буюу 50.0 хувиар тус тус өсч, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 13 буюу 11.3, гудамж талбайд 7 буюу 14.9, авто замд 10 буюу 55.6 хувиар тус тус буурч, төрийн бус байгууллагад үйлдэгдсэн хэрэг өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.



Гэр, орон сууц 31.2% | Гудамж, талбай 12.2% | Олон нийтийн газар 3.7% | Аж ахуйн нэгж 4.6% | Авто зам 2.4% | Бусад газар 45.9%

1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 101 буюу 30.9 хувь нь согтуугаар, 24 буюу 7.3 хувь нь тус тус хүүхэд болон эмэгтэй хүн оролцож, 15 буюу 4.6 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 16 буюу 4.9 хувь нь бүлэглэн, 1 буюу 0.3 хувь нь галт зэвсгээр үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Увс аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 157 буюу 48.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 73.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 8.1 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 14.5 нэгжээр их байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 310 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9 хэрэг буюу 3.0 хувиар, үүнээс 227 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 31 буюу 15.8 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 257 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 буюу 8.0 хувиар өссөн. Холбогдогчдын 20 буюу 7.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 6 буюу 23.1 хувиар буурч, 237 буюу 92.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 11.8 хувиар, 25 буюу 9.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин тус тус өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 334 хүн, 1 хуулийн этгээд хохирч, үүнээс 12 хүн нас барж, 126 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал, хохирсон хүн 1 буюу 0.3 хувиар, гэмтсэн хүн 2 буюу 1.6 хувиар тус тус буурч, нас барсан хүн 6 буюу 2.0 дахин өссөн байна.



4.2. Учирсан хохирол



Хүн, хуулийн этгээдэд учирсан 618.7 сая төгрөгийн хохирлын 60.6 хувийг нөхөн төлүүлж, 65.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 399.8 буюу 39.3 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 80.4 буюу 54.9 хувиар тус тус буурч, нөхөн төлүүлсэн хохирол 5.8 буюу 1.6 хувиар өссөн байна.

Тав. Зөрчил

Увс аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 16.442 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал 4562 буюу 38.4 хувиар, 16.553 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал 4625 буюу 38.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 15.566 буюу 94.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 283 буюу 1.7 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 80 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 513 буюу 3.1 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 15.885 хүн, 7 хуулийн этгээдийг 687.6 сая төгрөгөөр торгох, 251 хүнийг баривчлах, 410 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 4436 буюу 38.7 хувиар, баривчилсан шийтгэл 27 буюу 12.2 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 167 буюу 68.7 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Увс аймагт нийт 1493 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 282 буюу 23.3 хувиар өссөн байна.

ХОВД АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Ховд аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 3109 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 939 буюу 30.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2170 буюу 69.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 95 буюу 3.2, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 330 буюу 54.2 хувиар тус тус өсч, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 235 буюу 9.8 хувиар буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 481 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 118 буюу 32.5 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.3 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 374, сард 31, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/

Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Алтай сум	20	25	5	25.0
2	Булган сум	28	28		0.0
3	Буянт сум	25	38	13	52.0
4	Дарви сум	9	8	-1	-11.1
5	Дөргөн сум	3	4	1	33.3
6	Дуут сум		10	10	
7	Жаргалант сум	182	240	58	31.9
8	Зэрэг сум	5	9	4	80.0
9	Манхан сум	17	12	-5	-29.4
10	Мөст сум	12	7	-5	-41.7
11	Мянгад сум	7	8	1	14.3
12	Үенч сум	4	14	10	3.5 дах
13	Ховд сум	14	17	3	21.4
14	Цэцэг сум	13	26	13	2.0 дах
15	Чандмань сум	8	13	5	62.5
16	Эрдэнэбүрэн сум	15	14	-1	-6.7
17	Мөнххайрхан сум	1	8	7	8.0 дах



1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 363 буюу 75.5 хувь нь хөнгөн, 118 буюу 24.5 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 32.5 хувиар, хүнд гэмт хэрэг 32.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	8	5	-37.5	1.0
	Үүнээс: Хүнийг алах	3			
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	95	107	12.6	22.3
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3	1	-66.7	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	8	10	25.0	2.1
	Үүнээс: Хүчиндэх	7	7	0.0	1.5
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1			
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	170	277	62.9	57.6
	Үүнээс: Хулгайлах	92	118	28.3	24.5
	Залилах	16	52	3.3	10.8
	Дээрэмдэх	6	7	16.7	1.5
	Мал хулгайлах	39	54	38.5	11.2
7	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	2			
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	1	-75.0	0.2
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	4			
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	16	9	-43.8	1.9
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	7	5	-28.6	1.0
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг	13	36	2.8 дах	7.5
13	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1		0.2
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	35	28	-20.0	5.8
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	35	27	-22.9	5.6
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг		1		0.2

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ням гарагт үйлдэгдсэн хэрэг 6 буюу 13.3, даваа гарагт 10 буюу 15.6, мягмар гарагт 14 буюу 23.7, бямба гарагт 16 буюу 28.1, лхагва гарагт 18 буюу 37.5, пүрэв гарагт 24 буюу 58.5, баасан гарагт 30 буюу 61.2 хувиар тус тус өсчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06 -14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 64 буюу 75.3, 14-19 цагийн хооронд 47 буюу 47.5, 19-22 цагийн хооронд 13 буюу 21.7 хувиар тус тус өсч, 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 6 буюу 5.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 35 буюу 36.1, гудамж талбайд 18 буюу 40.9, олон нийтийн газарт 19 буюу 67.9, бусад газарт 59 буюу 55.7 хувиар тус тус өсч, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдэгдсэн хэрэг 2 буюу 9.1, авто замд 6 буюу 17.6, төрийн байгууллагад 5 буюу 17.9 хувиар тус тус буурч, Нийтийн тээвэрт болон төрийн бус байгууллагад өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Гэр, орон сууц 27.4% | Гудамж, талбай 12.9% | Олон нийтийн газар 9.8% | Аж ахуйн нэгж 4.2% | Авто зам 4.2% | Бусад газар 41.5%

1.9 Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 97 буюу 20.2 хувь нь согтуугаар, 51 буюу 10.6 хувь нь хүүхэд оролцож, 46 буюу 9.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 6 буюу 1.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас 53 буюу 11.0 хувь бүлэглэн үйлдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Ховд аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 270 буюу 56.1 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 49.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 8.4 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 9.0 нэгжээр бага байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 290 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 118 хэрэг буюу 68.6 хувиар, үүнээс 144 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 73 буюу 2.0 дахин хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 414 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99 буюу 31.4 хувиар өссөн. Холбогдогчдын 369 буюу 89.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 79 буюу 27.2 хувиар, 45 буюу 10.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 20 буюу 80.0 хувиар, 80 буюу 19.3 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.6 дахин тус тус өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн

Гэмт хэргийн улмаас 481 хүн хохирч, үүнээс 15 хүн нас барж, 131 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 122 буюу 34.0 хувиар өсч, нас барсан хүн 9 буюу 37.5, гэмтсэн хүн 5 буюу 3.7 хувиар тус тус буурсан байна.



4.2. Учирсан хохирол



Хүнд учирсан 1124.7 сая төгрөгийн хохирлын 50.0 хувийг нөхөн төлүүлж, 382.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 374.0 буюу 49.8, нөхөн төлүүлсэн хохирол 301.3 буюу 2.2 дахин тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 10.8 буюу 2.8 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил

Ховд аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 19.080 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5390 буюу 39.4 хувиар, 19.100 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5391 буюу 39.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 18238 буюу 95.6 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 145 буюу 0.8 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 101 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 596 буюу 3.1 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 17.940 хүн, 15 хуулийн этгээдийг 929.2 сая төгрөгөөр торгох, 374 хүнийг баривчлах, 771 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 5236 буюу 41.2 хувиар, баривчилсан шийтгэл 36 буюу 10.7 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 105 буюу 15.8 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Ховд аймагт нийт 1574 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 49 буюу 3.2 хувиар өссөн байна.

ХӨВСГӨЛ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 3922 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1003 буюу 25.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2919 буюу 74.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 653 буюу 20.0 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 716 буюу 32.5 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 63 буюу 5.9 хувиар буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 743 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 44 буюу 5.6 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.6 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 644, сард 54, хоногт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алаг-Эрдэнэ сум	57	43	-14	-24.6	13	Төмөрбулаг сум	33	27	-6	-18.2
2	Арбулаг сум	17	33	16	94.1	14	Түнэл сум	23	34	11	47.8
3	Баянзүрх сум	12	7	-5	-41.7	15	Улаан уул сум	14	17	3	21.4
4	Бүрэнтогтох сум	38	24	-14	-36.8	16	Ханх сум	7	6	-1	-14.3
5	Галт сум	20	10	-10	-50.0	17	Цагаан уул сум	17	9	-8	-47.1
6	Жаргалант сум	19	25	6	31.6	18	Цагааннуур сум	12	14	2	16.7
7	Их уул сум	15	8	-7	-46.7	19	Цагаан үүр сум	5	20	15	4.0 дах
8	Мөрөн сум	397	358	-39	-9.8	20	Цэцэрлэг сум	17	14	-3	-17.6
9	Рашаант сум	14	21	7	50.0	21	ЧандманьӨндөр	10	2	-8	-80.0
10	Рэнчинлхүмбэ сум	12	12			22	Шинэ-Идэр сум	9	10	1	11.1
11	Тариалан сум	13	20	7	53.8	23	Эрдэнэбулган сум	8	8		
12	Тосонцэнгэл сум	18	21	3	16.7						

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 559 буюу 75.2 хувь нь хөнгөн, 184 буюу 24.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 12.2 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 36.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	30	21	-30.0	2.8
	Үүнээс: Хүнийг алах	5	8	60.0	1.1
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	197	194	-1.5	26.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	9	2	-77.8	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	23	42	82.6	5.7
	Үүнээс: Хүчиндэх	20	29	45.0	3.9
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	2	3	50.0	0.4
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		1		0.1
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1			
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1			
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	456	383	-16.0	51.5
	Үүнээс: Хулгайлах	301	188	-37.5	25.3
	Залилах	33	51	54.5	6.9
	Дээрэмдэх	4	14	3.5 дах	1.9
	Мал хулгайлах	106	101	-4.7	13.6
9	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг		2		0.3
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	1			
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		2		0.3
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	3	3		0.4
13	Авлигын эсрэг гэмт хэрэг	5	11	2.2 дах	1.5
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	3	3.0 дах	0.4
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	44	40	-9.1	5.3
16	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1			
17	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	22	38	72.7	5.1
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	22	38	72.7	5.1

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ням гарагт үйлдэгдсэн хэрэг 1 буюу 1.1, баасан гарагт 13 буюу 14.0, мягмар гарагт 27 буюу 25.0 хувиар тус тус өсч, лхагва гарагт 10 буюу 8.7, даваа гарагт 27 буюу 18.1, бямба гарагт 22 буюу 20.0, пүрэв гарагт 26 буюу 20.8 хувиар тус тус буурсан байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 10 буюу 6.4, 14-19 цагийн хооронд 24 буюу 10.8, 19-22 цагийн хооронд 67 буюу 40.9 хувиар тус тус буурч, 22-06 цагийн хооронд 57 буюу 23.4 хувиар өссөн байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад авто замд үйлдэгдсэн хэрэг 18 буюу 90.0 хувиар, аж ахуйн нэгжид 10 буюу 2.0, төрийн байгууллагад 12 буюу 2.0 дахин тус тус өсч, бусад газарт үйлдэгдсэн хэрэг 10 буюу 4.5, гудамж талбайд 10 буюу 7.8, гэр орон сууцанд 48 буюу 14.5, олон нийтийн газарт 16 буюу 29.1 хувиар тус тус буурч, төрийн бус байгууллагад болон нийтийн тээвэрт үйлдэгдсэн хэрэг өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал

Нийт бүртгэгдсэн хэргийн 173 буюу 23.3 хувь нь согтуугаар, 29 буюу 3.9 хувь нь хүүхэд оролцож, 48 буюу 6.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 17 буюу 2.3 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 57 буюу 7.7 хувь нь бүлэглэн, 7 буюу 0.9 хувь нь галт зэвсгээр үйлдэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

Хөвсгөл аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 493 буюу 66.4 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 54.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 5.8 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 4.5 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 718 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 8 хэрэг буюу 1.1 хувиар буурсан, үүнээс 389 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 38 буюу 10.8 хувиар өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн

Нийт 447 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 буюу 1.8 хувиар буурсан. Холбогдогчдын 411 буюу 91.9 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.4 хувиар, 36 буюу 8.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 5.3 хувиар, 31 буюу 6.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.0 хувиар тус тус буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд

Гэмт хэргийн улмаас 735 хүн, 4 хуулийн этгээд хохирч, үүнээс 36 хүн нас барж, 223 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 56 буюу 7.1, нас барсан хүн 2 буюу 5.3 хувиар тус тус буурч, гэмтсэн хүн 10 буюу 4.7 хувиар өссөн байна.



4.2. Учирсан хохирол



Хүн, хуулийн этгээдэд учирсан 2515.6 сая төгрөгийн хохирлын 63.6 хувийг нөхөн төлүүлж, 143.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 330.0 буюу 15.1 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 909.5 буюу 2.3 дахин тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 20.7 буюу 12.6 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил

Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 21.331 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5104 буюу 31.5, 21.250 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5108 буюу 31.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 19578 буюу 91.8 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 499 буюу 2.3 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 151 буюу 0.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1103 буюу 5.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 20436 хүнийг 794.4 сая төгрөгөөр торгох, 326 хүнийг баривчлах, 488 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 4958 буюу 32.0, баривчилсан шийтгэл 54 буюу 19.9, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 96 буюу 24.5 хувиар тус тус өссөн байна.

2019 онд Хөвсгөл аймагт нийт 1630 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 136 буюу 9.1 хувиар өссөн байна.

ХЭНТИЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл

Хэнтий аймаг дахь цагдаагийн газар 2019 онд хүн, хуулийн этгээдээс 3930 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1242 буюу 31.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2688 буюу 68.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 19 буюу 0.5, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 245 буюу 24.6 хувиар тус тус өсч, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 226 буюу 7.8 хувиар буурсан байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Нийт 841 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 215 буюу 34.3 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 7.5 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 584, сард 49, хоногт 2 хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /сүүлийн 10 жилээр/

1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/



Д/д	Сум	2018 он	2019 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Батноров сум	24	43	19	79.2
2	Бат-ширээт сум	7	18	11	2.6 дах
3	Баянадарга сум	8	9	1	12.5
4	Баянмөнх сум	12	26	14	2.2 дах
5	Баян-овоо сум	18	16	-2	-11.1
6	Баянхутаг сум	37	72	35	94.6
7	Биндэр сум	15	21	6	40.0
8	Бор-Өндөр хот	16	30	14	87.5
9	Бэрх хот	12	19	7	58.3
10	Галшир сум	14	34	20	2.4 дах
11	Дадал сум	19	27	8	42.1
12	Дархан сум	28	38	10	35.7
13	Дэлгэрхаан сум	4	24	20	6.0 дах
14	Жаргалтхаан сум	44	55	11	25.0
15	Мөрөн сум	82	85	3	3.7
16	Норовлин сум	3	2	-1	-33.3
17	Өмнө-дэлгэр сум	23	39	16	69.6
18	Хэрлэн сум	226	246	20	8.8
19	Цэнхэрмандал	34	37	3	8.8

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал

Нийт бүртгэгдсэн хэргийн 661 буюу 78.6 хувь нь хөнгөн, 180 буюу 21.4 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 34.1 хувиар, хүнд гэмт хэрэг 35.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.5. Орон нутгийн гэмт хэрэгт эзлэх хувийн жин, сараар, 2019 он



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Аймгийн хэрэгт эзлэх хувь
		2018 он	2019 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	7	9	28.6	1.1
	Үүнээс: Хүнийг алах	2	4	2.0 дах	0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	170	179	5.3	21.3
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	8	11	37.5	1.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	19	14	-26.3	1.7
	Үүнээс: Хүчиндэх	17	12	-29.4	1.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.1
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		1		0.1
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	364	567	55.8	67.4
	Үүнээс: Хулгайлах	171	184	7.6	21.9
	Залилах	29	49	69.0	5.8
	Дээрэмдэх	6	5	-16.7	0.6
	Мал хулгайлах	120	287	2.4 дах	34.1
7	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг		2		0.2
8	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1			0.0
